

Төрийн байгууллагын ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС 2025

Мониторингийн тайлан



“Төрийн байгууллагын цахим хуудасны ил тод байдлын индекс 2025: Мониторингийн тайлан”-г IRIM судалгааны хүрээлэн өөрсдийн санаачилгаар 14 дэх жилдээ хийж гүйцэтгэв.

Мониторингийн баг:

Багийн ахлагч

Баянбатын Шинэцэцэг

Чанарын хяналтын менежер

Төмөрхүүгийн Бямбацэрэн

Судлаачид

Ганбаатарын Даваа

Мөнхтөмөрийн Саруул

Найдансүрэнгийн Нандинцэцэг

Пүрэвдоржийн Лхагвасүрэн

Будын Батхүү

Бавуугийн Одончимэг

Дагвадоржийн Энхтуул

Хянасан:

Хүрэлчулууны Баярмаа

Эх бэлтгэл, дизайн

Ганбаатарын Даваа

Мэдэгдэл

Тайланг түгээх, дамжуулах, татаж авах болон хэвлэх боломжтой бөгөөд IRIM судалгааны хүрээлэнгийн эх сурвалж ба зохиогчийн эрхийг зохих ёсоор дурдаж тайлангийн хэсгээс эшлэл татаж болно.

Мониторингийн тайланг эш татах

IRIM. Цахим ил тод байдлын индекс, УБ., 2025

Бидэнтэй холбогдох

Цахим шуудан: contact@irim.mn

Фейсбүүк/ Твиттер хуудас: @IRIMongolia

Вэбсайт: www.irim.mn

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕГ	Ерөнхий газар
НМИТБТ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	5
1. АРГА ЗҮЙ.....	9
ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН МОНИТОРИНГИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ.....	9
ОЛОН УЛСЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭ.....	9
МЭДЭЭЛЛИЙН ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКСИЙН ХҮРЭЭ.....	10
ИНДЕКС ТООЦОХ АРГАЧЛАЛ.....	15
ҮНЭЛГЭЭНИЙ НАЙДВАРТАЙ БАЙДАЛ БА ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТ.....	18
2. ҮР ДҮН.....	19
НЭГДСЭН ҮР ДҮН.....	19
ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ӨӨРЧЛӨЛТ.....	20
БҮРЭЛДЭХҮҮН ТУС БҮРИЙН ҮР ДҮН.....	21
БАЙГУУЛЛАГЫН 5 ТҮВШНИЙ АНГИЛЛЫН ЭРЭМБЭ.....	29
3. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	35
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖУУД.....	38
ХАВСРАЛТ 1. БАЙГУУЛЛАГЫН 5 ТҮВШНИЙ ЭРЭМБЭ.....	39

ДҮРС, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Дүрс 1. Цахим ил тод байдлыг зохицуулах эрх зүйн орчны гол өөрчлөлтүүд	8
Дүрс 2. Цахим ил тод байдлын арга зүй	10
Дүрс 3. Мэдээлэл цуглуулах арга	17
Дүрс 4. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн	20
Дүрс 5. Мэдээлэл авах эрхийн (RTI) практик тестийн үр дүн, хувиар	20
Дүрс 6. Мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн үзүүлэлт	23
Хүснэгт 1. Цахим ил тод байдлыг хэмжих олон улсын аргачлалууд	9
Хүснэгт 2. Мэдээлэл авах эрхийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал	11
Хүснэгт 3. Нээлттэй мэдээллийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал	13
Хүснэгт 4. Нээлттэй өгөгдлийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал	0
Хүснэгт 5. Төрийн мэдээллийн цахим ил тод байдлыг тооцон гаргахад хамрах байгууллагууд	16
Хүснэгт 6. Ил тод байдлын үнэлгээ, оноор	21
Хүснэгт 7. Ил тод байдал бүрэлдэхүүнээр	22
Хүснэгт 8. Мэдээлэл авах эрх дэд бүрэлдэхүүний үр дүн	23
Хүснэгт 9. Мэдээлэл авах хүсэлтэд хариулсан ангилал	24
Хүснэгт 10. Мэдээлэл авах хүсэлтийн хариултын хэлбэр	24
Хүснэгт 11. Хариу өгөөгүй байгууллагын тархалт	25
Хүснэгт 12. И-мэйл алдаатай байгууллагууд	25
Хүснэгт 13. Нээлттэй өгөгдөл дэд бүрэлдэхүүний үр дүн	27
Хүснэгт 14. Нээлттэй мэдээлэл дэд бүрэлдэхүүний үр дүн	28
Хүснэгт 15. Ил тод байдлын индекс, байгууллагын төрлөөр	29
Хүснэгт 16. Ил тод байдлын индекс, Яамдаар	30
Хүснэгт 17. Ил тод байдлын индекс, хэрэгжүүлэгч агентлагуудаар	31
Хүснэгт 18. Ил тод байдлын индекс, тохируулагч агентлагуудаар	32
Хүснэгт 19. Ил тод байдлын индекс, аймаг, нийслэлийн ЗДТГ-аар	33
Хүснэгт 20. Ил тод байдлын индекс, нийслэл дүүргийн ЗДТГ-аар	34
Хүснэгт 21. Ил тод байдлын индекс, парламент харьяа байгууллагаар	34

УДИРТГАЛ

Ил тод байдлын тухай ойлголт, үзэл баримтлал

Ил тод байдал нь орчин үеийн ардчилсан засаглалын салшгүй бүрэлдэхүүн хэсэг болж, төрийн байгууллагын үйл ажиллагаа, бодлого шийдвэр гаргалт, төсөв санхүүгийн зарцуулалт зэрэг олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй болгох зарчмыг илэрхийлдэг. Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах нь ил тод байдлыг хэрэгжүүлэх үндсэн механизмын нэг бөгөөд энэ эрхийг олон улсын болон үндэсний түвшинд эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажуулсан. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний эрхийн баримт бичгүүдэд мэдээлэл авах эрхийг суурь эрхийн нэг гэж үздэг бөгөөд Монгол Улс энэхүү эрхийг Үндсэн хуулиараа баталгаажуулсан. Ингэж мэдээлэл авах эрхийг хангаснаар иргэд төрийн үйл ажиллагаанд хяналт тавих, санал бодлоо илэрхийлэх, шийдвэр гаргах үйл явцад оролцох боломжийг нэмэгдүүлдэг. Энэ нь зөвхөн мэдээлэл түгээх үйл ажиллагаагаар хязгаарлагдахгүй, харин төрийн байгууллагын шийдвэр гаргалтын үндэслэл, хэрэгжилтийн явцыг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх замаар хариуцлагатай засаглалыг төлөвшүүлэхэд чиглэдэг.

Ил тод байдлыг хангах нь иргэдийн төрийн үйл ажиллагаанд оролцох боломжийг өргөжүүлэхийн зэрэгцээ төрд итгэх итгэлийг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл болдог.

Судалгаагаар мэдээллийн нээлттэй байдал өндөр улс орнуудад иргэдийн оролцоо идэвхтэй, бодлогын хэрэгжилт илүү үр дүнтэй байдаг нь тогтоогдсон байдаг. (OECD, 2017) Иймээс ил тод байдал нь төрийн үйл ажиллагааны үр нөлөө, бодлогын чанарыг дээшлүүлэх чухал нөхцөл юм.

Орчин үед ил тод байдлыг уламжлалт мэдээлэл түгээх хэлбэрээр хэрэгжүүлэх нь хангалтгүй болж, төрийн байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг цахим орчинд нээлттэй, шуурхай, хүртээмжтэй хүргэх шаардлага нэмэгдэж байна. Иймээс цахим ил тод байдал нь мэдээлэл авах эрхийг бодитоор хангах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлэх шинэ хэлбэрийн институцийн механизм болж хөгжиж байна (United Nations, 2020).

Түүнчлэн төрийн мэдээллийг цахим хэлбэрээр системтэй, стандартчилагдсан байдлаар нийтэд хүргэх нь засаглалын хариуцлагыг нэмэгдүүлэх, авлигын эрсдэлийг бууруулах, төр-иргэний харилцааны ил тод, нээлттэй байдлыг бэхжүүлэхэд чухал нөлөөтэй болохыг олон улсын судалгаанууд онцолдог (OECD, 2021; World Bank, 2020). Иймээс цахим ил тод байдлыг төрийн байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх, нөхцөлд үр нөлөөтэй хэрэгжүүлэх, түүнийг хянаж, сайжруулах нь сайн засаглалын зарчмыг хэрэгжүүлэх орчин үеийн нэг үндсэн чиглэл болж байна.

Цахим ил тод байдлыг хангахын ач холбогдол, үр нөлөө

Төрийн байгууллагын цахим ил тод байдал нь зөвхөн сайн засаглалын чухал хэмжүүр төдийгүй иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх, нийгмийн хөгжлийг дэмжихтэй шууд холбоотой хүчин зүйл юм. Өнөөгийн мэдээлэл, технологийн хурдацтай хөгжлийн үед засгийн газрууд иргэдэд нээлттэй, хүртээмжтэй мэдээлэл олгох нь ардчилсан засаглалын үндэс болж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ЭЗХАХБ (OECD, 2017) болон Дэлхийн банкны судалгаанд (World Bank, 2022) үндэслэн цахим ил тод байдал нь дараах дөрвөн үндсэн чиглэлд онцгой ач холбогдолтой гэж үзэж байна.

Нэгдүгээрт, цахим ил тод байдал нь хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Засаглалын шийдвэр гаргалт болон төсвийн зарцуулалтын мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох нь иргэдийн хяналтыг бодитой хэрэгжүүлэх үндсэн нөхцөлийг бүрдүүлдэг. Дэлхийн банкны судалгаагаар (World Bank, 2022) төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй байдлаар нийтэлдэг улс орнуудад төсвийн гүйцэтгэлийн үнэн зөв байдлын түвшин дунджаар 15 хувиар өндөр байдаг нь тогтоогдсон байна.

Хоёрдугаарт, нээлттэй өгөгдлийн бодлогыг хэрэгжүүлэх нь авлигатай тэмцэхэд чухал нөлөөтэй болохыг олон улсын судалгаа баталжээ. 71 улс орныг хамарсан харьцуулсан судалгааны үр дүнд нээлттэй өгөгдлийн гүйцэтгэл өндөр улс орнуудад авлигын түвшин харьцангуй доогуур байдаг нь тогтоогдсон байна.

(Rivero, 2020) ЭЗХАХБ болон G20-ийн авлигын эсрэг ажлын хэсгийн нэгтгэлд нээлттэй өгөгдлийн бодлого нь төрийн салбарын ил тод байдлыг дээшлүүлж, авлигатай тэмцэх үр дүнтэй хэрэгсэл болохыг онцолсон байна. (OECD, 2017)

Гуравдугаарт, мэдээллээр хангагдсан иргэд бодлого боловсруулалт болон шийдвэр гаргах үйл явцад илүү үр дүнтэй оролцох боломжтой байдаг. Иргэдийн оролцоо нэмэгдэхэд засгийн газар болон нийтийн байгууллагууд илүү хариуцлагатай, шинийг санаачилсан, үр дүнтэй ажилладаг болохыг Open Government Partnership-ийн судалгаа харуулж байна. (Open Government Partnership [OGP], 2023)

Дөрөвдүгээрт, цахим ил тод байдлыг хангах нь төрийн үйлчилгээний хүртээмж, шуурхай байдлыг сайжруулж, иргэдийн мэдээлэл авах үйл явцыг хялбарчилдаг. UNDP-ийн 2015–2023 оныг хамарсан үнэлгээний тайланд дурдсанаар цахим шилжилтийг дэмжсэн улс орнуудад үйлчилгээнд хандах хугацаа богиносж, дараалал буурч, ил тод байдал нэмэгдсэн нь төрийн үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан болохыг харуулсан байна. (UNDP, 2023)

Иймд энэхүү судалгаанд цахим ил тод байдлыг үнэлэх арга зүйн үндэс болгон дээрх дөрвөн хүрээг ашиглав.

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын олон улсын чиг хандлага

Өмнөх дөрвөн хүрээнд тулгуурлан цахим ил тод байдлыг үнэлэхийн тулд олон улсын чиг хандлагыг авч үзэх нь чухал юм. Өнөөгийн байдлаар төрийн байгууллагын **Нээлттэй өгөгдөлд суурилсан ил тод засаглалын чиг хандлага**: Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагын цахим ил тод байдлыг хангах бодлого нь нээлттэй өгөгдлийн тогтолцоонд суурилан хөгжих хандлагатай байна. ЭЗХАХБ -ийн 2023 оны OURdata индекс нь 36 гишүүн улс болон 4 нэгдэх шатанд буй орнуудын нээлттэй засаглалын өгөгдлийн бодлогыг 670 гаруй асуумжаар үнэлж, нээлттэй өгөгдөл нь нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх чухал хэрэгсэл болж байгааг онцолсон. Тухайлбал, Эстони Улс 2019 - 2023 он хүртэл OURdata индексийн 23 дугаар байрнаас 4 дүгээр байранд ахисан нь нээлттэй өгөгдлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлсний жишээ юм. (OECD, 2023) Төрийн мэдээллийг машинд уншигдах хэлбэрээр олон нийтэд нээлттэй байршуулах нь иргэд, судлаачид, хувийн хэвшлийн байгууллагууд бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, шинжилгээ хийх боломжийг нэмэгдүүлдэг. Дэлхийн банкны Дэлхийн засаглалын үзүүлэлт (WGI) нь 200 гаруй улс орны засаглалыг хариуцлагатай байдал, авлигын хяналт, засгийн газрын үр ашиг зэрэг зургаан хэмжүүрээр жил бүр үнэлдэг бөгөөд нээлттэй байдлыг эдгээр үзүүлэлтийн гол хүчин зүйл гэж тодорхойлдог. (World Bank, 2023) Иймээс ЭЗХАХБ болон Дэлхийн банк зэрэг олон улсын байгууллагууд нээлттэй өгөгдлийг сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлэх бодлогын гол хэрэгсэл гэж үзэж байна.

Иргэдийн оролцоонд суурилсан цахим ил тод байдлын хөгжил: Орчин үеийн цахим ил тод байдлын бодлого нь зөвхөн

цахим ил тод байдлыг хангах олон улсын чиг хандлага дараах гурван үндсэн чиглэлд хөгжиж байна.

мэдээлэл нийтлэхээс гадна иргэдийн мэдээлэл авах эрхийг хуулийн түвшинд баталгаажуулах чиглэлд хөгжиж байна. Одоогоор НҮБ-ын гишүүн 193 улсаас 137 орон мэдээллийн эрх чөлөөний хуулийг баталж, дэлхийн хүн амын 90 хувийг хамарч байна. Гэсэн хэдий ч дэлхийн улс орнуудын дөрөвний нэг буюу 56 орон одоог хүртэл мэдээлэлд хандах эрхийн хуульгүй хэвээр байгаа бөгөөд 2020–2023 оны хооронд зөвхөн 10 шинэ хууль батлагдсан нь өмнөх арван жилийн хурдтай харьцуулахад мэдэгдэхүйц удааширсан байна. Эдгээр 56 улсын 30 нь маш сул ардчилалтай, 17 нь нэг сая бага хүн амтай жижиг улс, үлдсэн 9 нь Африк, Азийн улсууд байна. (McIntosh, 2024) ЮНЕСКО нь 123 улсын мэдээлэлд үндэслэсэн 2025 оны тайландаа НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 16.10.2 болох мэдээлэлд хандах эрхийн талаар иргэдийг шийдвэр гаргахад чадавхжуулж, засгийн газрыг хариуцлагатай байлгах, олон нийтийн оролцоог дэмжих нь чухал гэдгийг онцолсон байна. (UNESCO, 2025)

Дижитал технологид суурилсан ил тод байдлын институцийн шинэчлэл: Цахим ил тод байдлыг хиймэл оюун ухаан, их өгөгдөл, нэгдсэн мэдээллийн сан зэрэг дэвшилтэт технологитой уялдуулан хөгжүүлэх нь олон улсын түвшинд нийтлэг чиг хандлага болж байна. НҮБ-ын 2024 оны Цахим засаглалын судалгаа нь 193 гишүүн улсын цахим засаглалын хөгжлийг иж бүрэн үнэлсэн бөгөөд анх удаа хиймэл оюун ухааны хэрэглээнд зориулсан тусгай нэмэлт хэсгийг багтааж, дэлхий нийтэд

цахим засаглалын хөгжилд мэдэгдэхүйц дэвшил гарсныг онцолсон байна. (DESA, 2024) Тус судалгааны дүнгээс харахад цахим засаглалын хөгжлийн индексийн дэлхийн дундаж мэдэгдэхүйц сайжирч, цахим засаглалын хөгжлөөс хоцорч буй хүн амын эзлэх хувь 2022 оны 45 хувиас 2024 онд 22.4 хувь болж буурсан байна. НҮБ-ын судалгаагаар ил тод байдал болон

хариуцлагыг хангах нь цахим засаглалын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээний туйлын чухал нөхцөл бөгөөд хиймэл оюун ухаан зэрэг дэвшилтэт технологийг хэрэглэх чадвар нь цахим засаглалын үр дүнтэй байдлыг хэмжих гол үзүүлэлт болдог байна. (DESA, 2024)


Монгол Улсын төрийн байгууллагын цахим ил тод байдлын эрх зүйн орчин

Монгол Улсад төрийн байгууллагын ил тод байдлыг хангах эрх зүйн үндэс нь иргэдийн мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь заалтад *"иргэн нь тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй"* гэж заасан нь төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Сүүлийн жилүүдэд төрийн байгууллагын цахим ил тод байдлыг бэхжүүлэх чиглэлээр засаглалын бодлого, хөтөлбөрүүдийг үе шаттай хэрэгжүүлж байна.

Тухайлбал, цахим засаглалыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлогын баримт бичгүүдэд төрийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, төрийн үйлчилгээг цахимжуулах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтуудыг тусгасан нь цахим ил тод байдлыг институцийн түвшинд бэхжүүлэхэд чиглэж байна. Ийнхүү эрх зүйн болон бодлогын орчныг үе шаттай бүрдүүлснээр төрийн байгууллагын үйл ажиллагааг илүү нээлттэй, хариуцлагатай болгох нөхцөл бүрдэж байна.

Дүрс 1. Цахим ил тод байдлыг зохицуулах эрх зүйн орчны гол өөрчлөлтүүд



Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль батлагдаж, 68 төрлийн мэдээллийг нийтлэх үүрэг тогтоосон.

2021



Shilen.gov.mn платформ нэвтэрч, 98 байгууллагын мэдээллийг нэг дороос харах боломж бүрдсэн. 12 дагалдах журам батлагдсан.

2022



"Авлигатай тэмцэх жил"-ийн хүрээнд Шилэн ажиллагааг улсын хэмжээнд өргөжүүлж, 98 шалгуур үзүүлэлтийн үнэлгээ нэвтэрсэн.

2023



Төрийн байгууллагын 6,006 цахим хуудсыг gov.mn нэгдмэл платформд нэгтгэх ажил хийгдэж байна. EGD1-д 46-р байрт дэвшсэн (2022: 74-р байр).

2024



Монгол Улсын Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги батлагдсанаар нээлттэй өгөгдлийн шаардлага шинэ түвшинд хүрч байна.

2025

1. Арга зүй

Цахим ил тод байдлын мониторингийн зорилго, ач холбогдол

“Хэмжиж чадахгүй зүйлийг сайжруулах боломжгүй” гэсэн зарчим нь төрийн байгууллагын цахим ил тод байдлыг үнэлэх

шаардлагын үндэс суурь хэмээн тодорхойлж болно.

Цахим ил тод байдлын индексийн зорилго

Төрийн байгууллагуудын цахим орчинд нийтэлж буй мэдээллийн хүртээмж, бүрэн байдал, стандартчилал, иргэдийн мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн түвшнийг нэгдсэн тоон аргачлалаар үнэлж, төрийн

байгууллагууд, бодлого боловсруулагчид болон иргэдэд нотолгоонд суурилсан мэдээлэл хүргэх, сайжруулалтын чиглэлийг тодорхойлох зорилготой. Индексийн гол зорилтууд нь:

ХЭМЖИХ

Монгол Улсын төрийн захиргааны 98 байгууллагын цахим ил тод байдлын түвшнийг нэгдсэн индексээр тооцож, байгууллагын төрлөөр эрэмбэлэх

01

ХАРЬЦУУЛАХ

Жил бүрийн үр дүнтэй харьцуулалт хийж, ахиц, бууралтын чиг хандлага болон шалтгааныг тодорхойлох

02

ТОДОРХОЙЛОХ

Мэдээлэл авах эрхийн практик тест, нээлттэй өгөгдлийн чанар зэрэг шинэ хэмжүүрээр тулгамдсан асуудал, сайн туршлагыг илрүүлэх

03

ЗӨВЛӨМЖ ГАРГАХ

Байгууллага болон бодлого боловсруулагчдад тодорхой, хэрэгжих боломжтой санал, зөвлөмж дэвшүүлэх

04

Цахим ил тод байдлын индексийн ач холбогдол, хэрэглээ

Цахим ил тод байдлыг бодитоор үнэлэх нь дараах үндсэн ач холбогдолтой:

- Хариуцлагын механизм:** Төрийн байгууллагууд мэдээлэл нийтлэхтэй холбоотой хууль, журамд заасан үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг бодит өгөгдөлд тулгуурлан үнэлэх боломжийг бүрдүүлнэ.
- Шийдвэр гаргалтыг дэмжих суурь мэдээлэл:** Ил тод байдлын хэрэгжилт сул байгаа чиглэлүүдийг тодорхойлж, бодлого боловсруулах болон нөөцийг оновчтой төлөвлөхөд шаардлагатай суурь мэдээллийг бий болгоно.
- Харьцуулалт хийх боломж:** Байгууллагуудын гүйцэтгэлийг харьцуулан үнэлснээр сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, харилцан суралцах нөхцөлийг бүрдүүлнэ.
- Иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх механизм:** Жил бүр тогтмол хийгддэг тул төрийн байгууллагуудын ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлж, иргэдийн төрд итгэх итгэлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулна.

Энэхүү индексийг байгууллагууд бие биеэсээ суралцах, цахим мэдээлэл түгээх чадавх болон сорилт, бэрхшээлийг тодорхойлох, энэ чиглэлийн бодлого, стратегийг тодорхойлох хэрэгсэл болгон ашиглахыг санал болгож байна.

Олон улсын шинжилгээний хүрээ

Цахим ил тод байдлын үнэлгээ нь олон улсын байгууллагын түвшинд өргөнөөр хэрэгжиж буй судалгааны чухал чиглэл бөгөөд доорх хүснэгтэд төрийн байгууллагын цахим ил тод байдалтай уялдаа бүхий гол үнэлгээний аргачлал, хэрэгслүүдийг харуулав.

IRIM нь эдгээр аргачлалд тулгуурлан Монгол Улсын эрх зүйн орчин болон төрийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн энэхүү арга зүйг шинэчлэн боловсрууллаа.

Хүснэгт 1. Цахим ил тод байдлыг хэмжих олон улсын аргачлалууд

Байгууллага	Хүрээ	Голлох хэмжүүр	Арга зүй
НҮБ — EGDИ	193 улс	Цахим үйлчилгээ, хүний капитал, дэд бүтэц	Вэбсайт мониторинг + статистик мэдээлэл
Centre for Law & Democracy — RTI Rating	136 улс	Мэдээлэл авах эрхийн хуулийн чанар, практик хэрэгжилт	Эрх зүйн баримт бичгийн шинжилгээ + практик тест
World Wide Web Foundation — Open Data Barometer	115 улс	Нээлттэй өгөгдлийн бэлэн байдал, чанар	Экспертийн үнэлгээ + вэбсайт мониторинг
Transparency International — Govt Defence Index	82 улс	Засаглалын ил тод байдал, авлигын эрсдэл	Баримт бичиг + интервью + вэбсайт
OGP — Independent Reporting Mechanism	78 улс	Амлалтын хэрэгжилт, иргэдийн оролцоо	Бие даасан судлаачийн хяналтын тайлан
OECD Digital Government Index	38 улс	Цахим засаглалын боловсронгуй байдал	Засгийн газрын тайлан + баталгаажуулалт
IRIM — Цахим ил тод байдлын индекс	98 байгууллага	Мэдээлэл авах эрх, нээлттэй өгөгдөл	Вэбсайт + мэдээлэл авах эрхийн (RTI) практик тест + нээлттэй өгөгдөл


Мэдээллийн цахим ил тод байдлын индексийн хүрээ

Цахим ил тод байдлыг зөвхөн нэг шалгуур үзүүлэлтээр хэмжих нь хангалтгүй юм. OECD-ийн нээлттэй өгөгдлийн судалгаанд дурдсанаар мэдээлэлд хандах эрхийн хөдөлгөөн нь нийтийн байгууллагуудаас мэдээлэл хүсэх хүсэлтэд хариу өгөх үүргийг онцолдог бол нээлттэй засаглалын өгөгдлийн хандлага нь өгөгдөлд хандах, ашиглах, дахин ашиглахтай холбоотой техник болон эрх зүйн асуудлыг хамардаг тул хоёр арга нь нэг нэгнийгээ нөхөж, иж бүрэн ил тод байдлыг бүрдүүлдэг. (OECD, 2013) Төрийн байгууллага цахим хуудсандаа их хэмжээний мэдээлэл байршуулсан боловч иргэдийн мэдээлэл авах хүсэлтэд хугацаанд нь хариу өгөхгүй тохиолдолд ил тод байдлыг бүрэн хангаж байна гэж үзэх боломжгүй байдаг. Мөн хуульд заасан мэдээллийг нийтэлж байгаа

хэдий ч нээлттэй форматгүй, дахин ашиглах боломжгүй хэлбэрээр байршсан тохиолдолд тухайн мэдээллийн нийгэм, эдийн засгийн үр өгөөж хязгаарлагддаг бөгөөд өгөгдлийн стандарт болон форматын нэгдмэл бус байдал нь системүүдийн харилцан уялдааг хязгаарлаж, нийгэм дэх өгөгдлийн ашиглалтыг бууруулдаг. (Chandrasekhar, 2025)

Иймд 2025 оны үнэлгээнд IRIM нь төрийн байгууллагын цахим ил тод байдлыг мэдээллийн хүртээмж, мэдээлэл авах эрхийн хэрэгжилт болон нээлттэй өгөгдлийн ашиглах боломжийг хамарсан гурван бие даасан, харилцан нөхөх хэмжүүрийн хүрээнд үнэлэх шинэчилсэн арга зүйг хэрэглэсэн болно.

ЦАХИМ ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС



Бүрэлдэхүүн 1. Мэдээлэл авах эрхийн хэрэгжилт

Мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн бүрэлдэхүүн нь төрийн байгууллагын цахим ил тод байдлыг эрхэд суурилсан хандлагаар үнэлэх үндсэн хэсэг бөгөөд иргэд мэдээлэл авах эрхээ бодитоор хэрэгжүүлэх боломж хэр бүрдсэн, мөн энэ

эрх практикт хэрхэн хэрэгжиж байгааг тодорхойлоход чиглэнэ.

Үнэлгээний хүрээнд мэдээлэл хүсэх сувгийн хүртээмж, хүсэлт гаргах журам болон хугацааны зохицуулалтын тодорхой байдал, мэдээлэл өгөхөөс татгалзах хууль ёсны үндэслэлийн ил тод байдал,

шийдвэрийг давж заалдах боломж зэрэг эрх зүйн болон байгууллагын зохицуулалтыг хамруулан авч үздэг. Түүнчлэн мэдээлэл авах хүсэлтийн хэрэгжилтийн статистик мэдээлэл, тайлагналын ил тод байдлыг үнэлдэг.

Үүнээс гадна мэдээлэл авах хүсэлтийн хэрэгжилтийг бодит нөхцөлд шалгах практик тестийг ашиглан урьдчилан бэлэн байх ёстой мэдээлэл болон тодорхой

хугацаа, боловсруулалт шаардсан мэдээллийн хоёр төрлөөр хүсэлт гаргаж, хариу өгөх хугацаа, мэдээллийн бүрэн байдал, албан ёсны байдал болон татгалзсан тохиолдолд үндэслэлийн хууль зүйн нийцлийг үнэлсэн болно.

Энэ бүрэлдэхүүн хэсэг нь дотроо дөрвөн дэд бүрэлдэхүүнд хуваагдаж, нийт жингийн 40%-ийг эзэлнэ.

Хүснэгт 2. Мэдээлэл авах эрхийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал

RTI-Мэдээлэл авах эрх

Яагаад энэ бүрэлдэхүүн чухал вэ?

Иргэн мэдээлэл авахыг хүссэн үед байгууллага хариу өгч чадаж байна уу? Зөвхөн механизм бий болгосон эсэхийг биш, тухайн механизм бодитоор ажиллаж байгаа эсэхийг R4 практик тестээр шалгадаг. НҮБ-ын E-Participation индексэд Монгол 37-р байртай боловч бодит хариу өгөх тогтолцоо сул байгааг энэ бүрэлдэхүүн илрүүлдэг.

R1 Онлайн хандалтын механизм **8%**

R2 Журмын тодорхой байдал, хугацаа, татгалзах үндэслэл **8%**

R3 Хүсэлт шийдвэрлэлтийн статистик, тайлан **6%**

R4 Практик нийцлийн тест — бодит хүсэлт илгээж хариу авах **18%** ★ шинэ

Нийт жин: **40%** · Дэд бүрэлдэхүүн: 4 · Нийт асуулт: 20

R1: Онлайн хандалтын механизм

Иргэн мэдээлэл авах хүсэлтээ цахимаар гаргах боломж төрийн байгууллагуудад хэр зэрэг бүрдсэн байгааг энэ хэсэгт шалгасан. Вэбсайтад онлайн хүсэлтийн форм байрласан эсэх, хүсэлт хүлээн авах албан ёсны и-мэйл хаяг тодорхой заасан эсэх, хүсэлт гаргахад урьдчилсан бүртгэл эсвэл тусгай нэвтрэлт шаардахгүй байх, хүсэлт гаргах заавар байрласан эсэх, хүсэлт хариуцсан нэгж болон холбоо барих мэдээлэл тодорхой байх зэрэг шалгуураар үнэлэв.

R2: Журмын тодорхой байдал

Хуульд заасан хариу өгөх хугацаа болон сунгах нөхцөл тодорхой тайлбарласан эсэх, мэдээлэл өгөхөөс татгалзах хууль ёсны үндэслэлийг жагсаасан эсэх, татгалзсан тохиолдолд давж заалдах журам болон шат дамжлагыг тодорхойлсон эсэх, мэдээлэл авахтай холбоотой төлбөрийн нөхцөл тодорхой байх зэрэг шалгуураар үнэлэв.

R3: Хэрэгжилтийн ил тод байдал

Байгуулга мэдээлэл авах хүсэлтийн статистик мэдээллийг нийтэд нээлттэй байршуулдаг эсэхийг энэ хэсэг шалгадаг. Нийт хүсэлтийн тоо, шийдвэрлэсэн, татгалзсан, шилжүүлсэн гэсэн ангиллаар задаргаа мэдэгдсэн эсэх, дундаж шийдвэрлэх хугацааг тайлагнасан эсэх зэрэг шалгуур багтана.

R4: Практик нийцлийн тест

Вэбсайтын мэдээллийг шалгаад зогсохгүй, бодит хүсэлт илгээж хариуг хэмжих аргыг ашиглав. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан эрхийн үндсэн дээр 98 байгууллагын бүртгэлтэй и-мэйл хаягаар хоёр төрлийн хүсэлт явуулав.

Эхний хүсэлт нь байгууллагаас харьцангуй бага хүчин чармайлт шаарддаг "Ажилтныг сонгон шалгаруулах журам"-ыг хүссэн хүсэлт байв. Хоёрдох хүсэлт нь нэлээд хүчин чармайлт шаардагдах буюу "иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын тоог" сүүлийн гурван жилээр нэгтгэн гаргасан

тайланг хүссэн хүсэлт байв. Хариуг хуульд заасан ажлын 5 хоногийн хугацаанд ирсэн эсэх, хүссэн мэдээллийг бүрэн хэмжээгээр өгсөн эсэх, хариу нь албан ёсны эх сурвалж, гарын үсэг, тамга, албан хаяг бүхий үндэслэлтэй тайлбартай эсэх зэрэг гурван шалгуураар үнэлэв.

Тооцоолол

Байгуулга тус бүрийн Мэдээлэл авах эрхийн (RTI) оноог дараах томъёогоор тооцоолно:

$$RTI = \frac{R1*8+R2*8+R3*6+R4*18}{40}$$

Энд R1, R2, R3, R4 тус бүр 0–100 оноотой бөгөөд 40 гэдэг нь дэд бүрэлдэхүүний жингүүдийн нийлбэр (8+8+6+18=40) юм. Үр дүн нь 0–100 хэмжүүрт байна.

98 байгууллагын нэгдсэн дундаж RTI оноог дараах байдлаар тооцоолно:

$$RTI \text{ дундаж} = \Sigma (\text{байгуулга бүрийн RTI оноо}) \div 98$$

Бүрэлдэхүүн 2: Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан суурь мэдээллийн ил тод байдал

Энэхүү бүрэлдэхүүн нь төрийн байгууллага хуульд заасан заавал нийтлэх мэдээллийг цахим хуудсаараа дамжуулан бодитоор нээлттэй байршуулж байгаа эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Энэ нь байгууллагын идэвхтэй ил тод байдлын хэрэгжилтийн үндсэн түвшнийг тодорхойлох ач холбогдолтой.

Үнэлгээний хүрээнд дараах таван чиглэлийн мэдээллийн ил тод байдлыг хамруулан авч үздэг. Үүнд:

- Байгууллагын стратеги, чиг үүрэг, бүтэц, үйл ажиллагааны талаарх мэдээллийн ил тод байдал;

- Хүний нөөцийн бодлого болон сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийн ил тод байдал;
- Төсөв, санхүү болон аудитын мэдээллийн ил тод байдал;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, тендерийн баримт бичиг, шалгаруулалтын үр дүнгийн ил тод байдал;
- Иргэдээс санал, гомдол хүлээн авах, шийдвэрлэх эргэх холбооны механизмын нээлттэй байдал.

Ингэснээр байгууллага олон нийтэд шаардлагатай суурь мэдээллийг тогтмол,

системтэй, шалгаж баталгаажуулах боломжтой хэлбэрээр нийтэлж байгаа эсэхийг үнэлэх боломж бүрдэнэ.

Энэ бүрэлдэхүүн дараах таван дэд бүрэлдэхүүнд хуваагдаж, нийт жингийн 40%-ийг эзэлнэ.

Хүснэгт 3. Нээлттэй мэдээллийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал

Нээлттэй мэдээлэл-Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль

Яагаад энэ бүрэлдэхүүн чухал вэ?

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 төрлийн мэдээллийг байгууллага вэбсайтаа байршуулсан эсэхийг шалгадаг. Энэ бол цахим ил тод байдлын 'суурь давхарга' — хуулийн шаардлагыг хангаж байна уу гэдгийг хэмждэг хамгийн томоохон бүрэлдэхүүн юм.

D1 Байгууллагын ил тод байдал — эрхэм зорилго, бүтэц, гүйцэтгэл **8%**

D2 Хүний нөөцийн бодлого — сул орон тоо, журам, үнэлгээ **8%**

D3 Төсөв, санхүүгийн ил тод байдал — шилэн данс, аудит **8%**

D4 Худалдан авах ажиллагааны ил тод байдал — тендер, үр дүн **8%**

D5 Иргэдийн эргэх холбоо — санал асуулга, уулзах цагийн хуваарь, чат **8%**

Нийт жин: **40%** · Дэд бүрэлдэхүүн: **5** · Нийт асуулт: **35**

D1: Байгууллагын ил тод байдал

Байгууллагын эрхэм зорилго, бүтэц, удирдлагын бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тайлан зэрэг байгууллагыг таниулах суурь мэдээллийг вэбсайтад байршуулсан эсэхийг шалгана.

D2: Хүний нөөцийн бодлогын ил тод байдал

Сул орон тооны зар, ажилтныг сонгон шалгаруулах журам, үнэлгээний тогтолцоо болон хөдөлмөрийн дотоод журмыг нийтэд нээлттэй байршуулсан эсэхийг үнэлнэ.

D3: Санхүүгийн ил тод байдал

Шилэн данс системийн шаардлагын дагуу төсөв, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хуульд заасан хугацаанд нийтэлсэн эсэхийг шалгана.

D4: Худалдан авах ажиллагааны ил тод байдал

Тендер шалгаруулалтын мэдээлэл, гэрээний дүн, үр дүнг нийтэлсэн эсэх зэрэг худалдан авах ажиллагааны ил тод байдлыг шалгана.

D5: Иргэдийн эргэх холбоо

Иргэдтэй уулзах цагийн хуваарь, санал хүлээн авах цахим хэлбэр, чат болон гомдол гаргах боломжийг вэбсайтад бүрдүүлсэн эсэхийг үнэлнэ.

Тооцоолол

Байгуулга тус бүрийн хуулийн хэрэгжилтийн оноог дараах томъёогоор тооцоолно:

$$DD = \frac{D1+D2+D3+D4}{40}$$

Энд D1–D5 тус бүр 0–100 оноотой бөгөөд бүх дэд бүрэлдэхүүний жин тэнцүү (тус бүр 8%) байна. 98 байгууллагын нэгдсэн дундаж оноог дараах байдлаар тооцоолно:

$$DD \text{ дундаж} = \Sigma(\text{байгуулга бүрийн } DD \text{ оноо}) \div 98$$

Бүрэлдэхүүн 3: Нээлттэй өгөгдөл

Нээлттэй өгөгдлийн бүрэлдэхүүн нь төрийн байгууллагын цахим мэдээлэл иргэд, судлаачид болон бусад хэрэглэгчдэд бодитоор хүрч, ашиглагдах нөхцөл бүрдсэн эсэхийг үнэлэхэд чиглэнэ. Энэ бүрэлдэхүүн нь мэдээлэл зөвхөн цахим орчинд байршуулсан эсэхийг бус, харин хэрэглээнд бэлэн, дахин ашиглах боломжтой хэлбэрээр нийтлэгдсэн эсэхийг тодорхойлох зорилготой.

Үнэлгээний хүрээнд нээлттэй өгөгдлийг машинд уншигдах форматтай нийтэлсэн эсэх, татаж авах боломжтой байдал, шинэчлэлтийн огноо болон тайлбар

мэдээллийн бүрдэл, архивын хүртээмж, өгөгдлийн задралын түвшин, мөн өгөгдлийн формат тогтвортой, дахин ашиглах боломжтой эсэх зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг хамруулан авч үздэг.

Ингэснээр төрийн байгууллагын мэдээлэл хэрэглэгчдэд хүртээмжтэй, тогтвортой, дахин ашиглах боломжтой, практикт ашиглагдах бэлэн байдлаар хүрч байгаа эсэхийг цогцоор нь үнэлэх боломж бүрдэнэ. Энэ бүрэлдэхүүн дараах дөрвөн дэд бүрэлдэхүүнд хуваагдаж, нийт жингийн 20%-ийг эзэлнэ.

Хүснэгт 4. Нээлттэй өгөгдлийн дэд индексийн бүтэц, тооцох аргачлал

Нээлттэй өгөгдөл
Яагаад энэ бүрэлдэхүүн чухал вэ? Мэдээлэл вэбсайтад байгаа ч иргэдэд бодитоор хүрч байна уу? PDF-ийн оронд машин уншигдах форматаар нийтлэгдэж байна уу? Монгол Улсын “Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги” (2025) нэвтэрсэн орчинд нээлттэй өгөгдлийн чанар нь хиймэл оюун ухааны бодлогын суурь болж байна.
01 Нээлттэй өгөгдлийн чанар — CSV/XLS формат, мета дата, архив 8%
02 Навигаци & 3 товшилтод хүрэх боломж 4%
03 Mobile хэрэглэгчийн хүртээмж, хуваалцах боломж 4%
04 HTTPS, ачаалах хурд, холбоосны найдвартай байдал 4%
Нийт жин: 20% · Дэд бүрэлдэхүүн: 4 · Нийт асуулт: 21

O1: Нээлттэй өгөгдлийн чанар

Байгууллагын вэбсайт дахь мэдээлэл нь иргэд болон судлаачид дахин ашиглах боломжтой нээлттэй форматад байгаа эсэхийг шалгадаг. Мэдээллийг CSV, XLS буюу машинд уншигдах форматаар нийтэлсэн эсэх, мета дата буюу тайлбар мэдээлэл хавсаргасан эсэх, архивын мэдээлэл хадгалсан эсэх зэрэг шалгуураар үнэлэв.

O2: Навигаци ба мэдээллийн хүртээмж

Иргэн вэбсайтад орж хайж буй мэдээлэлдээ хэр хялбар хүрч чадах талыг шалгадаг. Тухайлбал, хэрэглэгч 3 товшилтоор хэрэгцээт мэдээлэлдээ хүрэх боломжтой эсэх, навигацийн бүтэц ойлгомжтой эсэх зэрэг шалгуурыг багтаав.

O3: Хэрэглэгчийн хүртээмж

Гар утасны хэрэглэгчид вэбсайтыг саадгүй ашиглах боломжтой эсэх, мэдээллийг хуваалцах, татаж авах боломж байгаа эсэхийг шалгаж үнэлэв.

Индекс тооцох аргачлал

Төрийн байгууллагын цахим ил тод байдлын индекс нь гурван үндсэн бүрэлдэхүүн хэсгийн жинлэгдсэн нийлбэрээр тооцогдоно. Бүрэлдэхүүн хэсгүүдийн жинг асуултын тоонд тулгуурлан бус, харин тухайн бүрэлдэхүүн нь цахим ил тод байдлыг тодорхойлоход үзүүлэх бодлогын болон арга зүйн ач холбогдлын түвшинг харгалзан тогтоосон.

O4: Техникийн найдвартай байдал

HTTPS аюулгүй холболт хангагдсан эсэх, вэбсайтын ачаалах хурд хэвийн байдалд байгаа эсэх, дотоод холбооснуудын найдвартай байдал зэрэг техникийн үзүүлэлтүүдийг шалгаж үнэлэв.

Тооцоолол

Байгуулга тус бүрийн нээлттэй өгөгдлийн оноог дараах томъёогоор тооцоолно:

$$OD = \frac{O1*8+O2*4+O3*4+O4*4}{20}$$

Энд O1, O2, O3, O4 тус бүр 0–100 оноотой бөгөөд 20 гэдэг нь дэд бүрэлдэхүүний жингүүдийн нийлбэр (8+4+4+4=20) юм.

98 байгууллагын нэгдсэн дундаж оноог дараах байдлаар тооцоолно:

$$OD \text{ дундаж} = \Sigma(\text{байгуулга бүрийн } OD \text{ оноо}) \div 98$$

$$\text{Төрийн байгууллагын цахим ил тод байдал} = \frac{1}{I} \sum_{k=1}^I (0.4A_k + 0.2B_k + 0.4C_k)$$

A – Мэдээлэл авах эрхийн хэрэгжилт (жин: 40%)

B- Нээлттэй өгөгдөл (жин: 20%)

C – Нээлттэй мэдээлэл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт (жин: 40%)

I – Үнэлэгдсэн байгууллагын тоо (98)

k – Үндсэн байгууллага тус бүрийн дугаар

Байгуулга тус бүрийн нэгдсэн оноог тооцоолохдоо А, В, С гурван бүрэлдэхүүн тус бүрийн оноог (0–100 хэмжүүрт)

тэдгээрийн жинтэй үржүүлж, нийлбэрийг тооцно.

Онооны систем

Оноо	Ангилал	Тайлбар
1	Бүрэн хангасан	Тодорхой, шинэчлэгдсэн, олдоцтой, бүрэн эхээрээ нийтлэгдсэн
0.5	Хэсэгчлэн хангасан	Байгаа ч бүрэн бус, хуучирсан, эсвэл олоход хүндрэлтэй
0	Хангаагүй	Огт байхгүй, холбоос ажиллахгүй, эсвэл шаардлагыг үл хангах

Индексийн ангиллын түвшин

Оноо	Ангилал	Тайлбар
≥ 80%	Сайн	Цахим ил тод байдлыг бий болгох процедур, нөөц, хариуцлагыг бүрэн бэхжүүлсэн
65–79%	Хангалттай	Байгууллага мэдээллийг нийтлэх процедур, нөөц, хариуцлагыг бэхжүүлж байгаа
50–64%	Сул	Зарим үзүүлэлт байгаа ч тогтвортой хангах чадавхыг бэхжүүлэх шаардлагатай
35–49%	Хангалтгүй	Суурь түвшний процедур, нөөц байгаа ч тогтвортой хангах чадвар хомс
< 35%	Муу	Цахимаар мэдээлэл нийтлэх процедур, нөөц, хариуцлага бараг байхгүй

Мэдээлэл цуглуулах хүрээ

Индексийн үр дүнг тооцон гаргахдаа дараах төрийн байгууллагуудыг жил бүр хамруулдаг.

Хүснэгт 5. Төрийн мэдээллийн цахим ил тод байдлыг тооцон гаргахад хамрах байгууллагууд

№	Байгууллагын төрөл	Тоо
1	Монгол Улсын яамд	16
2	Хэрэгжүүлэгч агентлагууд	30
3	Тохируулагч агентлагууд	11
4	Аймаг, нийслэлийн ЗДТГ	22
5	Нийслэл, дүүргийн ЗДТГ	9
6	Парламентын харьяа байгууллага	10
	Нийт	98

Эдгээр 6 төрлийн байгууллагын нийт тоо 2021 онд 88, 2022 онд 93 байсан бол 2023 оноос хойш 98 болжээ. 2024 оны 7 дугаар сарын 10-нд УИХ-ын 13 дугаар тогтоолын дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын нэрийг "Монополын эсрэг газар" болгон өөрчилсөн бөгөөд үүнийхээ хамт тохируулагч агентлагаас хэрэгжүүлэгч агентлаг болгон ангиллыг нь ч өөрчилжээ. 2025 онд Ургамал хамгааллын газар нь

хэрэгжүүлэгч агентлагийн жагсаалтад шинээр нэмэгдсэн боловч тус байгууллага одоогоор албан ёсны цахим хуудасгүй байгаа тул 2025 оны үнэлгээнд хамрагдаагүй болно. Төрийн захиргааны байгууллагын жагсаалтыг гаргахдаа Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг батлах тухай эрх зүйн актыг үндэслэл болгон ашигласан.

Мэдээлэл цуглуулах арга

Мэдээлэл цуглуулалт нь гурван үндсэн аргад тулгуурлана. Мэдээллийн үнэн зөв байдлыг хангах үүднээс бие даасан хоёр

судлаач хяналтын үнэлгээ хийж, зөрүүтэй тохиолдолд гуравдагч судлаачийн шийдвэрийг эцэслэх болно.

Дүрс 2. Мэдээлэл цуглуулах арга

Вэбсайтын мониторинг

Байгууллага тус бүрийн албан ёсны вэбсайт болон shilen.gov.mn платформыг судлаач шууд нэвтэрч шалгана. Нотолгоог дэлгэцийн зураг, URL холбоос, татаж авсан файлаар баримтжуулна. Шалгах хугацаа: 2026 оны I улирал.



Мэдээлэл авах эрхийн практик тест

Судалгааны баг 98 байгууллагад хялбар (low-effort) болон хэцүү (high-effort) гэсэн хоёр хүсэлтийг и-мэйлээр илгээж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хугацааг ажиглана. Хариу бүрийг хугацаа, бүрэн байдал, албан ёсны байдлаар үнэлнэ.



Техникийн шалгалт

Вэбсайтын ачаалах хурд, HTTPS хамгаалалт, гар утасны тохиромжтой байдал, эвдэрсэн холбоосыг автоматжуулсан хэрэгслийн тусламжтайгаар шалгана. Нээлттэй өгөгдлийн формат (CSV, XLS, API), архивын байдлыг мөн шалгана.



Үнэлгээний найдвартай байдал ба чанарын баталгаажуулалт

Судалгааны үнэлгээний найдвартай байдал, үр дүнгийн бодит байдлыг хангах зорилгоор мэдээлэл цуглуулах болон боловсруулах бүх үе шатанд чанарын баталгаажуулалтын олон шатлалт хяналтын механизмыг ашигласан.

Нэгдүгээрт, шалгуур үзүүлэлт бүрийн үнэлгээг урьдчилан боловсруулсан стандартчилсан үнэлгээний заавар (coding guideline)-д тулгуурлан гүйцэтгэж, үнэлгээ бүрийг нотлох баримтаар баталгаажуулсан. Энэ нь судлаачдын хоорондын үнэлгээний зөрүүг багасгах нөхцөлийг бүрдүүлсэн.

Хоёрдугаарт, анхны үнэлгээг бие даасан хоёр дахь судлаач давхар шалгаж баталгаажуулсан бөгөөд үнэлгээний зөрүү гарсан тохиолдолд хэлэлцэн зөвшилцөх зарчмаар шийдвэрлэсэн. Зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд гуравдагч үнэлгээ хийж эцсийн шийдвэрийг тогтоосон.

Гуравдугаарт, үнэлгээний үр дүнд статистикийн хувьд дундаж үзүүлэлтээс мэдэгдэхүйц өндөр эсвэл бага оноо авсан байгууллагуудыг дахин хянан шалгаж, нотолгооны үндэслэл болон үнэлгээний зөвшөөрөгдөх байдлыг баталгаажуулсан.

Дөрөвдүгээрт, индексийн тооцоололд ашигласан өгөгдлийн бүрэн байдал, логик нийцлийг шалгах зорилгоор мэдээллийн сангийн дотоод шалгалтыг хийж, алдаатай болон зөрүүтэй өгөгдлийг засварласан.

Ийнхүү олон шатлалт хяналтын аргачлалыг ашигласнаар судалгааны үр дүнгийн найдвартай байдал, давтагдах боломж (replicability), мөн бодит байдал (validity)-ыг хангах нөхцөл бүрдсэн болно.

2. Үр дүн

2025 оны цахим ил тод байдлын үнэлгээний үр дүнг нэгдсэн индекс, бүрэлдэхүүн тус бүрийн түвшин, байгууллагын ангиллаар харуулсан үр дүн, мөн, таван түвшний ангилалд суурилсан шинжилгээний хүрээнд нэгтгэн харууллаа.

Энэхүү үнэлгээнд ашигласан арга зүй 2025 онд шинэчлэгдсэн тул өмнөх оны (2024) тоон үзүүлэлттэй шууд харьцуулах боломж хязгаарлагдмал хэдий ч цахим ил тод байдлын хөгжлийн ерөнхий хандлага, чиглэлийн өөрчлөлтийг тодорхойлох боломжтой юм.

Нэгдсэн үр дүн

2025 ОНЫ НЭГДСЭН ИНДЕКС

45 /100

Хангалтгүй

$$21 \times 0.40 + 43 \times 0.20 + 69 \times 0.40 = 8.4 + 8.6 + 27.6 \approx 45$$

98 байгууллага


76 шалгуур үзүүлэлт

2026 оны I улирал


2025 оны цахим ил тод байдлын нэгдсэн индекс 45/100 оноо авч, хангалтгүй түвшинд үнэлэгдлээ. Энэхүү үзүүлэлтийг 2024 оны 69 хувийн “хангалттай” гэсэн үр дүнтэй тоон утгаар шууд харьцуулах боломж хязгаарлагдмал юм. Учир нь уг 2025 оны үнэлгээнд арга зүйг шинэчилж, мэдээлэл авах эрхийн (RTI) хэрэгжилтийг хэмжих практик тест болон нээлттэй өгөгдлийн шинэ шалгуур үзүүлэлтүүдийг нэвтрүүлснээр индексийн тооцооллын логик бүхэлдээ өөрчлөгдсөн.

Гэсэн хэдий ч уг үр дүн нь цахим ил тод байдлын бодит нөхцөл байдлын талаар чухал дүгнэлт гаргах боломжийг олгож байна. Төрийн байгууллагуудын цахим хуудсанд мэдээлэл байршуулах түвшин харьцангуй сайн байгаа боловч иргэдийн мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх, мөн мэдээллийг нээлттэй өгөгдлийн хэлбэрээр хүртээмжтэй хүргэх бодит чадавх сул хэвээр байна. Ялангуяа мэдээлэл авах эрхийн (RTI) практик тестийн үр дүн нь мэдээлэл авах эрхийн хэрэгжилт бодит түвшинд хангалтгүй байгааг анх удаа баримтжуулсан нь энэхүү судалгааны онцлох үр дүн болж байна.

Дүрс 3. Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн



Дүрс 4. Мэдээлэл авах эрхийн (RTI) практик тестийн үр дүн, хувиар



98 байгууллагын 60 орчим хувь буюу дийлэнх нь 'Хангалтгүй' болон 'Муу' ангилалд багтаж байгаа бол 'Хангалттай' ангилалд 15 байгууллага (15%) орж, 'Сайн' ангилалд нэг ч байгуулга хүрч чадаагүй байна.

Арга зүйн шинэчлэлийн нөлөө

Мэдээлэл авах эрхийн (RTI) практик тест (R4, 18% жин) нь анх удаа хэрэгжсэн бөгөөд нийт байгууллагын дийлэнх (88%-аас дээш) хуульд заасан хугацаанд хариу өгөөгүй нь индексийг эрс бууруулсан гол хүчин зүйл болсон. Энэ нь 'цаасан дээрх' ил тод байдал болон 'бодит' ил тод байдлын хоорондох зөрүүг анх удаа тоон байдлаар илрүүлж байна.

Цахим ил тод байдлын өөрчлөлт

IRIM нь 2010 оноос хойш төрийн байгууллагын ил тод байдлын үнэлгээг жил бүр тогтмол хэрэгжүүлж ирсэн. 2025 оны үнэлгээ нь арга зүйн хувьд шинэчлэгдсэнтэй холбоотойгоор өмнөх онуудын үр дүнтэй тоон утгаар шууд харьцуулах боломж хязгаарлагдмал байна.

Иймд уг тайланд 2025 оны үр дүнг хугацааны динамикт суурилан харьцуулах бус, харин цахим ил тод байдлын хөгжлийн ерөнхий чиг хандлага, өөрчлөлтийн агуулгын хүрээнд авч үзэх нь зүйтэй.

Хүснэгт 6. Ил тод байдлын үнэлгээ, оноор

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

Он	Индекс	Ангилал	Тайлбар
2019	51.8	Сул	Төрийн байгууллагуудын Цахим Ил Тод Байдлын Индекс-ийг анх удаа боловсруулж нийтэд танилцуулсан.
2020	53.7	Сул	Цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор байгууллагаас судалгаа авах боломж хязгаарлагдсан учир үнэлгээг өмнөх арга зүйгээр буюу веб мониторингийн аргад тулгуурлан явуулсан.
2021	60.2	Сул	2019 онд Монгол Улсын цахим ил тод байдлын эрх зүйн орчин 0.65 оноо авч хангалттай түвшинд үнэлэгдэж байсан бол даруй 2 жилийн дараа гэхэд уг үзүүлэлт буурсан.
2022	63.1	Сул	2021 онтой харьцуулахад бага зэрэг өссөн байгаа ч ангиллын хувьд ялгаагүй 'сул' түвшинд хэвээр байсан.
2023	65.2	Хангалттай	Төрийн байгууллагуудын цахим ил тод байдлын индексийг хэмжиж эхэлснээс хойш анх удаа 'хангалттай' түвшинд гарсан.
2024	69.0	Хангалттай	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт тогтворжиж, нээлттэй мэдээлэл 5.3% иар өссөн.
2025	45.0	Хангалтгүй	Арга зүйн шинэчлэл — Мэдээлэл авах эрхийн (RTI) практик тест, нээлттэй өгөгдөл шалгах арга зүй нэвтэрсэн.

Бүрэлдэхүүн тус бүрийн үр дүн

Гурван бүрэлдэхүүний үнэлгээний үр дүн харилцан адилгүй байдалтай бөгөөд бүрэлдэхүүн тус бүрд тодорхой хэв маяг ажиглагдаж байна. Тодруулбал, хуульд заасан мэдээллийг цахим хэлбэрээр нийтлэхтэй холбоотой идэвхтэй ил тод байдлын хэрэгжилт харьцангуй сайн түвшинд байгаа бол мэдээлэл авах эрхийн хэрэгжилт болон нээлттэй өгөгдлийн хүртээмжийн үзүүлэлтүүд сул түвшинд байна.

Энэхүү зөрүү нь төрийн байгууллагууд мэдээллийг нийтлэх үүргээ тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байгаа хэдий ч иргэдийн мэдээлэл авах эрхийг бодитоор хангах, мөн мэдээллийг дахин ашиглах боломжтой хэлбэрээр хүргэх чиглэлд бодит ахиц хангалтгүй байгааг илтгэж байна.

Хүснэгт 7. Ил тод байдал бүрэлдэхүүнээр

Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

Дэд бүрэлдэхүүн	Оноо	Ангилал
Мэдээлэл авах эрх →	24 / 100	(Муу)
R1 — Хандалтын механизм	46	Хангалтгүй
R2 — Журмын тодорхой байдал	42	Хангалтгүй
R3 — Хэрэгжилтийн статистик	22	Муу
R4 — Практик нийцлийн тест	8	Муу
Нээлттэй өгөгдөл →	41 / 100	(Хангалтгүй)
O1 — Нээлттэй өгөгдлийн чанар	20	Муу
O2 — Навигаци & хүртээмж	52	Сул
O3 — Хэрэглэгчийн хүртээмж	50	Сул
O4 — Техникийн найдвартай байдал	65	Хангалттай
Нээлттэй мэдээлэл →	68 / 100	(Хангалттай)
D1 — Байгууллагын ил тод байдал	88	Сайн
D2 — Хүний нөөцийн ил тод байдал	72	Хангалттай
D3 — Санхүүгийн ил тод байдал	78	Хангалттай
D4 — Худалдан авах ажиллагаа	74	Хангалттай
D5 — Иргэдийн эргэх холбоо	30	Муу

Мэдээлэл авах эрхийн хэрэгжилт

Энэхүү бүрэлдэхүүн нь байгууллагын вэбсайт дахь мэдээлэл авах эрхийн механизм болон түүний бодит хэрэгжилтийг нэгэн зэрэг үнэлсэн бөгөөд төрийн байгууллагын цахим ил тод байдлын индексийн нийт жингийн 40 хувийг эзэлнэ. Мэдээлэл авах эрхийн

бүрэлдэхүүний 98 байгууллагын нэгдсэн дундаж оноо 24 буюу 100 онооны харьцаанд "Муу" ангилалд багтав.


Дэд бүрэлдэхүүний үр дүн дараах байдалтай байна.

Хүснэгт 8. Мэдээлэл авах эрх дэд бүрэлдэхүүний үр дүн

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

Дэд бүрэлдэхүүн	Оноо	Ангилал	Үр дүн
МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ → 24 / 100 (МУУ)			
R1 — Хандалтын механизм	46	Хангалтгүй	R1 буюу онлайн хандалтын механизмын дундаж оноо 46 байсан нь байгууллагуудын тал хувь гаруй нь иргэнд хүсэлт гаргах хаяг, форм, зааврыг хэсэгчлэн байршуулсан боловч бүрэн гүйцэд хангаагүй байгааг харуулж байна.
R2 — Журмын тодорхой байдал	42	Хангалтгүй	R2 буюу журмын тодорхой байдлын дундаж оноо 42 байв. Хуульд заасан хугацааг тайлбарласан байгуулга харьцангуй олон ч татгалзах үндэслэл, давж заалдах журмыг тодорхойлсон байгуулга цөөн байв.
R3 — Хэрэгжилтийн статистик	22	Муу	R3 буюу хэрэгжилтийн статистикийн дундаж оноо 22 байсан нь хамгийн сул үзүүлэлт болов. Байгууллагуудын дийлэнх нь мэдээлэл авах хүсэлтийн тоо, шийдвэрлэлтийн мэдээллийг нийтэлдэггүй байв.
R4 — Практик нийцлийн тест	8	Муу	R4 буюу практик нийцлийн тестийн дундаж оноо 8 байв. Ажилтныг сонгон шалгаруулах журам хүссэн хүсэлтэд хуульд заасан хугацаанд хариу өгсөн байгуулга нийт байгууллагын 12 хувь, өргөдөл гомдлын гурван жилийн нэгтгэсэн тайлан хүссэн хүсэлтэд хариу өгсөн байгуулга 4 хувь байв.

Дүрс 5. Мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн үзүүлэлт



Дээрх үр дүнгүүд нь мэдээлэл авах эрхийн хуулийн хэрэгжилт байгууллагуудын дийлэнхэд нь бодит ач холбогдолгүй хэвээр байгааг нотолж байна.

Хүснэгт 9. Мэдээлэл авах хүсэлтэд хариулсан ангилал

Хариуны ангилал	Тоо	Хувь	Хуулийн дүгнэлт
Хариу өгсөн	3	3%	Хуульд бүрэн нийцсэн.
Холбоос илгээсэн	11	11%	Хэсэгчилсэн хариу — мэдээлэл шууд өгөөгүй, вэбсайт холбоос явуулсан.
Мэдээлэл хүсэж байгаа зорилго, шалтгаан асуусан	3	3%	ХУУЛИЙН ЗӨРЧИЛ НМИТБТ хуулийн 14.1.2-хүсэлт гаргагч нээлттэй мэдээлэл авах бол мэдээлэл авах зорилго, үндэслэлээ тайлбарлахгүй байх эрхтэй.
Утас/бусад руу шилжүүлсэн	10	10%	НМИТБТ хууль төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, иргэнтэй цахимаар харилцах, мэдээллийг шуурхай, хялбар хүргэх гэдгийг онцолдог.
Бичгээр ирүүлэх шаардлага тавьсан	4	4%	ХУУЛИЙН ЗӨРЧИЛ — НМИТБТ хуулийн 17.1.6-мэдээлэл авах хүсэлтийг шийдвэрлэж, хариуг хүсэлт гаргагчийн сонгосон хэлбэрээр өгөх.
Хариу өгөөгүй	68	69%	ХУУЛИЙН ЗӨРЧИЛ — Ажлын тав хоногийн хугацаанд хариу өгөөгүй нь хуулийн 15.6.1, 15.6.2 дүгээр зүйлийн зөрчил.

Хариу өгсөн байгууллагуудын хариуны агуулгыг шинжилбэл хэд хэдэн давтагдах хэлбэр ажиглагдлаа:

Хүснэгт 10. Мэдээлэл авах хүсэлтийн хариултын хэлбэр

Хариуны хэлбэр	Тоо	Жишээ хариу
Төрийн албаны зөвлөлийн тогтоолын холбоос явуулсан	11	"Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоол..."
Утас дугаар л өгсөн	8	".....утсаар холбогдоорой"
Өөр хүн/мэйл рүү шилжүүлсэн	5	".....хаягаар явуулахыг хүсье"
Цаасан хүсэлт шаардсан	4	"Хүсэлтийг цаасан хэлбэрээр албажуулж ирүүлнэ үү"
Яагаад хэрэгтэй вэ? гэж асуусан	3	"Ямар байдлаар ашиглах үндэслэлийг илгээнэ үү"
Бодит мэдээлэл/баримт бичиг явуулсан	3	Хавсралт + тайлбар бичгийн хамт явуулсан.

Мэдээлэл авах хүсэлтэд хариу өгсөн байгууллагуудын дунд мэдээллийг хуульд заасан хугацаанд өгөхийн оронд цахим холбоос, хамраалтай мэргэжилтний утасны дугаар дамжуулах, өөр нэгж рүү

шилжүүлэх зэрэг хариу түгээмэл ажиглагдсан бол бодит мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлсэн тохиолдол харьцангуй цөөн байв. Мөн зарим байгууллага цахимаар ирүүлсэн хүсэлтэд

цаасан хүсэлт шаардах, мэдээлэл ашиглах үндэслэл тодруулах зэрэг нэмэлт процедур тавьсан нь мэдээлэл авах хүртээмжид

тодорхой хүндрэл үүсгэж байна. Хариу өгөөгүй 68 байгууллагыг байгууллагын төрлөөр нь задлан харвал:

Хүснэгт 11. Хариу өгөөгүй байгууллагын тархалт

Байгууллагын төрөл	Нийт тоо	Хариу өгөөгүй	Хариу өгөөгүй хувь
Яамд	16	14	88%
Хэрэгжүүлэгч агентлагууд	30	21	70%
Тохируулагч агентлагууд	11	8	73%
Аймаг, нийслэлийн ЗДТГ	22	14	64%
Нийслэл, дүүргийн ЗДТГ	9	8	89%
Парламентын харьяа	10	3	30%

Доорх 5 байгууллагад мэйл буруу илгээгдсэн эсвэл хоосон мэйл ирсэн тул Мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн

тестийн дүнд тооцоогүй болно. Байгууллагын сайт дээр байгаа албан ёсны веб сайт нь алдаатай.

Хүснэгт 12. И-мэйл алдаатай байгууллагууд

№	Байгууллагын нэр	Асуудал
1	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	Мэйл яваагүй — мэйл хаяг олдоогүй
2	Төрийн худалдан авах ажиллагааны газар	Мэйл яваагүй — мэйл хаяг олдоогүй
3	Архивын ерөнхий газар	Хоосон мэйл ирсэн
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ЕГ	Мэйл яваагүй — мэйл хаяг олдоогүй
5	Дорноговь аймаг	Мэйл яваагүй — мэйл хаяг олдоогүй

Мэдээлэл авах эрхийн (RTI) практик тестийн гол дүгнэлт

Хялбар хүсэлтэд (low-effort) хариу өгсөн байгууллага нийт байгууллагын 12%, хэцүү хүсэлтэд (high-effort) 4% байна. Хариу ирүүлсэн байгууллагын дийлэнх нь мэдээлэл хүсэхдээ зөвхөн цахим форм ашиглахыг заасан бөгөөд хүссэн мэдээллийг бүрэн ирүүлээгүй байна. Гэвч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зорилго, зарчим нь мэдээллийг иргэдэд шуурхай, хүртээмжтэй, цахим хэлбэрээр хүргэхэд чиглэдэг. Энэ хүрээнд “цахим хэлбэр”-ийг зөвхөн веб формоор хязгаарлахгүйгээр имэйл, веб форм, e-Mongolia, чат систем, өргөдөл, гомдлын платформ зэрэг олон сувгийг хамруулан ойлгох боломжтой юм. Энэ нь мэдээлэл авах эрхийн практик хэрэгжилт хууль тогтоомжоос хамаагүй хоцорч байгааг харуулна.

Монгол Улсын мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийн практик тестийн үр дүнг олон улсын жишиг тоо баримттай харьцуулахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Ирландад 2023 оны гуравдугаар улиралд засгийн газрын яамд мэдээлэл авах хүсэлтийн 80 хувьд нь хугацаанд нь хариу өгсөн байна (Cabinet Office UK, 2023). Их Британид 2024 онд нийт 83,041 мэдээлэл авах хүсэлт ирснээс 76 хувь нь хуульд заасан хугацаанд шийдвэрлэгдсэн бөгөөд засгийн газрын яамдын хувьд энэ үзүүлэлт 89 хувьд хүрсэн байна (Cabinet Office UK, 2025).

OGP-д гишүүн 67 улсын дотор 63 хувь нь мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийг хянах хуулийн зохицуулалттай боловч олонх нь хэрэгжилтийн статистик мэдээллийг бүрэн нийтэлдэггүй байна. (Youan Zhao, 2023)

Азийн орнуудад мэдээлэл авах эрхийн бодит хэрэгжилтийн түвшин харилцан адилгүй байна.

Нээлттэй өгөгдөл

Энэхүү бүрэлдэхүүн нь байгууллагын вэбсайт дахь мэдээллийн чанар, хүртээмж болон техникийн найдвартай байдлыг үнэлсэн бөгөөд төрийн байгууллагын цахим ил тод байдлын индексийн нийт жингийн 20 хувийг эзэлдэг.

Энэтхэгт 2021–2022 оны RTI хүсэлтийн мэдээлэл өгөх түвшин ихээхэн ялгаатай байв. Хамгийн сул муж болох Тамил Наду хүссэн мэдээллийн зөвхөн 14 хувийг, Махараштр муж 23 хувийг л өгсөн бол харин Бихар мужид 67 хувь хүрчээ (Sangathan, 2022).

Харин Монгол Улсын хувьд low effort хүсэлтэд 12 хувь, high effort хүсэлтэд 4 хувь хариу өгсөн нь хөгжингүй орнуудын 76–89 хувийн үзүүлэлттэй харьцуулахад мэдэгдэхүйц доогуур түвшинд байгааг харууллаа. Энэхүү харьцуулалт нь Монгол Улсад мэдээлэл авах эрхийн тухай хууль эрх зүйн хүрээнд бүрдсэн боловч хэрэгжилтийг бодит үйл ажиллагааны түвшинд сайжруулах, институцийн чадавх болон хариу өгөх практикт нэмэлт анхаарал хандуулах шаардлага байгааг харуулж байна.

Нээлттэй өгөгдөл ба нээлттэй өгөгдлийн бүрэлдэхүүний 98 байгууллагын нэгдсэн дундаж оноо 41 байсан бөгөөд "Хангалтгүй" ангилалд багтав. Дэд бүрэлдэхүүнүүдийн үр дүн дараах байдалтай байна.

Хүснэгт 13. Нээлттэй өгөгдөл дэд бүрэлдэхүүний үр дүн

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

Дэд бүрэлдэхүүн	Оноо	Ангилал	Үр дүн
Нээлттэй өгөгдөл → 41 / 100 (Хангалтгүй)			
О1: Нээлттэй өгөгдлийн чанар	20	Муу	О1 буюу нээлттэй өгөгдлийн чанарын дундаж оноо 20 байсан нь хамгийн сул үзүүлэлт болов. Байгууллагуудын дийлэнх нь мэдээллийг PDF хэлбэрт нийтэлдэг бөгөөд машинд уншигдах CSV, XLS формат ашигладаг байгуулга маш цөөн байв.
О2: Навигаци & хүртээмж	52	Сул	О2 буюу навигаци ба мэдээллийн хүртээмжийн дундаж оноо 52 байв. Байгууллагуудын тал хувь гаруй нь хэрэглэгчдэд харьцангуй хялбар навигацийн бүтэцтэй хэдий ч 3 товшилтоор мэдээлэлд хүрэх стандартыг бүрэн хангаж байгаа байгууллага цөөн байв.
О3: Хэрэглэгчийн хүртээмж	50	Сул	О3 буюу хэрэглэгчийн хүртээмжийн дундаж оноо 50 байв. Гар утасны нийцтэй байдлын хувьд сайжирсан хэдий ч мэдээллийг хуваалцах, татаж авах боломж хязгаарлагдмал хэвээр байв.
О4: Техникийн найдвартай байдал	65	Хангалттай	О4 буюу техникийн найдвартай байдлын дундаж оноо 65 байсан нь дөрвөн дэд бүрэлдэхүүний хамгийн өндөр үзүүлэлт болов. Байгууллагуудын дийлэнх нь HTTPS аюулгүй холболтыг хангасан байсан боловч вэбсайтын дотоод холбоосны тасалдал нийтлэг асуудал хэвээр байв.

OECD-ийн 2023 оны OURdata индексийн үр дүнгээс харахад өндөр үнэ цэнтэй өгөгдлийн сангийн зөвхөн 48 хувь нь нээлттэй байдлаар нийтэд хүртээмжтэй байгаа бол санхүү, нийтийн хариуцлагатай холбоотой өгөгдлийн санг нээлттэй байдлаар нийтэлж буй тохиолдол ховор байна. (CPI, 2024)

40 улсыг хамарсан тус индексийн үр дүнгээр Солонгос, Франц, Польш, Эстони тэргүүлж байгаа бөгөөд OECD-ийн орнуудын 80–89 хувьд өндөр үнэ цэнтэй өгөгдлийг нээлттэй, машин уншигдах

форматаар нийтэлдэг байна. Харин мета дата чанар болон API хандалт нь зөвхөн 50 орчим хувийн өгөгдлийн санд хангагдаж байна. OECD-ийн орнуудын хувьд өгөгдлийн хүртээмж болон бэлэн байдлын шалгуурт харьцангуй сайн үзүүлэлт гаргаж байгаа боловч гадаад оролцогч талуудтай хамтран ажиллаж өгөгдлийн дахин ашиглалтыг дэмжих чиглэлд нэмэлт хүчин чармайлт шаардлагатай байна (CPI, 2024).

Монгол Улсын хувьд байгууллагуудын дийлэнх мэдээллийг PDF хэлбэрээр нийтэлдэг бөгөөд машинд уншигдах

формат ашиглах явдал хязгаарлагдмал байгаа нь OECD-ийн 80–89 хувийн

жишигтэй харьцуулахад мэдэгдэхүй хоцрогдол байгааг харуулж байна.

Нээлттэй мэдээлэл, нийтийн мэдээллийн ил тод байдал

Энэхүү бүрэлдэхүүн нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан 68 төрлийн мэдээллийг байгуулга вэбсайтаа байршуулсан эсэхийг шалгадаг бөгөөд нийт жингийн 40 хувийг эзэлдэг.

Нээлттэй мэдээллийн бүрэлдэхүүний 98 байгууллагын нэгдсэн дундаж оноо 68 байсан бөгөөд гурван бүрэлдэхүүний хамгийн өндөр үзүүлэлт болов. Дэд бүрэлдэхүүнүүдийн үр дүн дараах байдалтай байна.

Хүснэгт 14. Нээлттэй мэдээлэл дэд бүрэлдэхүүний үр дүн

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

Дэд бүрэлдэхүүн	Оноо	Ангилал	Үр дүн
Нээлттэй мэдээлэл → 68 / 100 (Хангалттай)			
D1: Байгууллагын ил тод байдал	88	Сайн	D1 буюу байгууллагын ил тод байдлын дундаж оноо 88 байсан нь хамгийн өндөр үзүүлэлт болов. Байгууллагуудын дийлэнх нь эрхэм зорилго, бүтэц, гүйцэтгэлийн тайланг тогтмол нийтэлдэг байна.
D2: Хүний нөөцийн ил тод байдал	72	Хангалттай	D2 буюу хүний нөөцийн бодлогын дундаж оноо 72 байв. Сул орон тооны зарлал болон сонгон шалгаруулалтын журмыг нийтэлж буй байгуулга сүүлийн жилүүдэд нэмэгдсэн хэдий ч үнэлгээний тогтолцоог нийтэлж буй байгуулга харьцангуй цөөн байна.
D3: Санхүүгийн ил тод байдал	78	Хангалттай	D3 буюу санхүүгийн ил тод байдлын дундаж оноо 78 байв. Шилэн данс системийн нэвтрэлт нь санхүүгийн мэдээллийн нийтлэлтийг эрс сайжруулсан боловч аудитын тайланг хугацаанд нь нийтэлдэг байгуулга нийт байгууллагын талаас бага байна.
D4: Худалдан авах ажиллагаа	74	Хангалттай	D4 буюу худалдан авах ажиллагааны дундаж оноо 74 байв. Тендерийн мэдэгдлийг нийтэлж буй байгуулга нэмэгдсэн боловч гэрээний үр дүн, гүйцэтгэлийн тайланг нийтэлдэг байгуулга цөөн байна.
D5: Иргэдийн эргэх холбоо	30	Муу	D5 буюу иргэдийн эргэх холбооны дундаж оноо 30 байсан нь хамгийн сул үзүүлэлт болов. Иргэдтэй харилцах цахим боломж буюу чат, санал авах форм, гомдол гаргах цахим системийг бүрдүүлсэн байгуулга нийт байгууллагын маш цөөн хэсгийг эзэлж байна.

Байгууллагын 5 түвшний ангиллын эрэмбэ

Доорх хүснэгтүүдэд нийт 98 байгууллагыг яам, хэрэгжүүлэгч агентлаг, тохируулагч агентлаг, аймгийн ЗДТГ, дүүргийн ЗДТГ, парламентын харьяа байгууллага гэсэн 6 ангиллаар тус бүр эрэмбэлэн харуулав. Оноо нь тухайн байгууллагын нэгдсэн

цахим ил тод байдлын индекс бөгөөд Мэдээлэл авах эрх (RTI) (40%), Нээлттэй өгөгдөл (20%), Нээлттэй мэдээлэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль (40%) гурван бүрэлдэхүүний жинлэгдсэн нийлбэр юм.

Хүснэгт 15. Ил тод байдлын индекс, байгууллагын төрлөөр

Байгууллагын төрөл	Тоо	Дундаж оноо	Ангилал
Парламентын харьяа	10	54	Сул
Яамд	16	52	Сул
Хэрэгжүүлэгч агентлагууд	30	44	Хангалтгүй
Тохируулагч агентлагууд	11	42	Хангалтгүй
Аймаг, нийслэлийн ЗДТГ	22	43	Хангалтгүй
Дүүргийн ЗДТГ	9	39	Хангалтгүй

Хүснэгт 16. Ил тод байдлын индекс, Яамдаар

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 16 байгууллага · Дундаж оноо 52 / 100						
1	Сангийн яам	75	Хангалттай	59	71	94
2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам	75	Хангалттай	56	77	92
3	Эдийн засаг, хөгжлийн яам	70	Хангалттай	51	66	90
4	Боловсрол, шинжлэх ухааны яам	65	Хангалттай	46	62	86
5	Эрүүл мэндийн яам	62	Сул	42	59	84
6	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	60	Сул	40	57	82
7	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	58	Сул	37	54	80
8	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	55	Сул	33	55	78
9	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуулын яам	52	Сул	29	52	76
10	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	49	Хангалтгүй	27	49	72
11	Эрчим хүчний яам	47	Хангалтгүй	24	47	70
12	Хууль зүй, дотоод хэргийн яам	43	Хангалтгүй	19	43	67
13	Гадаад харилцааны яам	39	Хангалтгүй	16	39	63
14	Батлан хамгаалах яам	35	Хангалтгүй	11	33	59
15	Зам, тээврийн хөгжлийн яам	27	Муу	6	24	49
16	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам	24	Муу	5	21	45

Хүснэгт 17. Ил тод байдлын индекс, хэрэгжүүлэгч агентлагуудаар

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 30 байгууллага · Дундаж оноо 44 / 100						
1	Үндэсний статистикийн хороо	79	Хангалттай	65	79	93
2	Татварын ерөнхий газар	79	Хангалттай	65	77	94
3	Улсын бүртгэлийн ерөнхий газар	77	Хангалттай	60	75	94
4	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	75	Хангалттай	59	71	93
5	Гаалийн ерөнхий газар	74	Хангалттай	57	74	92
6	Төрийн худалдан авах ажиллагааны газар	71	Хангалттай	54	69	90
7	Ашигт малтмал, газрын тосны газар	63	Сул	43	62	84
8	Стандарт, хэмжил зүйн газар	60	Сул	38	60	82
9	Боловсролын ерөнхий газар	57	Сул	34	56	80
10	Цагдаагийн ерөнхий газар	54	Сул	30	53	78
11	Нийгмийн даатгалын ерөнхий газар	54	Сул	30	53	78
12	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар	50	Сул	25	46	76
13	Онцгой байдлын ерөнхий газар	47	Хангалтгүй	20	46	74
14	Иргэний нисэхийн ерөнхий газар	44	Хангалтгүй	18	42	72
15	Хөрөнгө оруулалт худалдааны газар	42	Хангалтгүй	15	41	70
16	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	40	Хангалтгүй	14	38	67
17	Шүүх шинжилгээний ерөнхий газар	40	Хангалтгүй	14	38	67
18	Мал эмнэлгийн ерөнхий газар	37	Хангалтгүй	13	31	63
19	Санхүүгийн зохицуулах хороо	36	Хангалтгүй	12	33	61
21	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	34	Муу	11	29	59
21	Архивын ерөнхий газар	27	Муу	6	23	51
22	Гадаадын иргэн, харьяатын газар	26	Муу	6	21	49
23	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	25	Муу	5	19	47
24	Цаг уур, орчны шинжилгээний газар	23	Муу	5	17	43
25	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар	21	Муу	5	15	41
26	Усны газар	19	Муу	2	14	39
27	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	21	Муу	5	15	41
28	Ойн газар	20	Муу	6	12	37
29	Соёл, урлагийн газар	18	Муу	5	10	35
30	Жижиг, дунд үйлдвэрийн газар	17	Муу	5	8	33

Хүснэгт 18. Ил тод байдлын индекс, тохируулагч агентлагуудаар

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 11 байгууллага · Дундаж оноо 42 / 100						
1	Харилцаа холбоо зохицуулах хороо	73	Хангалттай	57	69	91
2	Хил хамгаалах ерөнхий газар	60	Сул	38	56	84
3	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	58	Сул	35	58	82
4	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	52	Сул	28	48	77
5	Зэвсэгт хүчний жанжин штаб	39	Хангалтгүй	14	39	65
6	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	37	Хангалтгүй	14	34	61
7	Эрчим хүчний зохицуулах хороо	36	Хангалтгүй	11	34	61
8	Төрийн албаны зөвлөл	32	Муу	9	29	56
9	Монополын эсрэг газар	29	Муу	8	25	53
10	Оюуны өмчийн газар	26	Муу	6	23	47
11	Биеийн тамир, спортын улсын хороо	22	Муу	5	17	41

Хүснэгт 19. Ил тод байдлын индекс, аймаг, нийслэлийн ЗДТГ-аар

Сайн | >80 Хангалттай | 65-79 Сул | 50-64 Хангалтгүй | 35-49 Муу | <35

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 22 байгууллага · Дундаж оноо 43 / 100						
1	Орхон аймаг	71	Хангалттай	54	68	90
2	Дархан-Уул аймаг	67	Хангалттай	48	63	87
3	Өмнөговь аймаг	63	Сул	43	58	86
4	Сэлэнгэ аймаг	60	Сул	38	56	84
5	Хөвсгөл аймаг	56	Сул	32	53	82
6	Дорнод аймаг	51	Сул	27	42	80
7	Ховд аймаг	52	Сул	28	46	78
8	Нийслэлийн ЗДТГ	52	Сул	28	48	77
9	Архангай аймаг	49	Хангалтгүй	25	44	76
10	Булган аймаг	45	Хангалтгүй	19	41	72
11	Улаанбаатар хотын захирагчийн алба	45	Хангалтгүй	19	42	72
12	Хэнтий аймаг	42	Хангалтгүй	17	35	70
13	Сүхбаатар аймаг	38	Хангалтгүй	14	32	65
14	Дорноговь аймаг	36	Хангалтгүй	12	29	63
15	Баян-Өлгий аймаг	35	Хангалтгүй	12	27	61
16	Төв аймаг	31	Муу	9	25	57
17	Завхан аймаг	29	Муу	6	24	55
18	Говь-Алтай аймаг	27	Муу	5	21	53
19	Увс аймаг	26	Муу	6	19	49
20	Баянхонгор аймаг	24	Муу	5	15	47
21	Дундговь аймаг	23	Муу	5	14	45
22	Говьсүмбэр аймаг	20	Муу	5	12	40

Хүснэгт 20. Ил тод байдлын индекс, нийслэл дүүргийн ЗДТГ-аар

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 9 байгууллага · Дундаж оноо 39 / 100						
1	Хан-Уул дүүрэг	52	Сул	28	52	76
2	Баянзүрх дүүрэг	51	Сул	28	46	76
3	Сонгинохайрхан дүүрэг	48	Хангалтгүй	24	42	74
4	Баянгол дүүрэг	42	Хангалтгүй	17	37	70
5	Сүхбаатар дүүрэг	39	Хангалтгүй	14	33	67
6	Чингэлтэй дүүрэг	35	Хангалтгүй	12	27	61
7	Налайх дүүрэг	26	Муу	6	21	49
8	Багануур дүүрэг	21	Муу	5	15	39
9	Багахангай дүүрэг	18	Муу	5	12	33

Хүснэгт 21. Ил тод байдлын индекс, парламент харьяа байгууллагаар

Сайн >80	Хангалттай 65-79	Сул 50-64	Хангалтгүй 35-49	Муу <35
------------	--------------------	-------------	--------------------	-----------

№	Байгууллагын нэр	Нийт	Ангилал	Мэдээлэл авах эрх	Нээлттэй өгөгдөл	Нээлттэй мэдээлэл
Нийт 10 байгууллага · Дундаж оноо 54 / 100						
1	Монгол банк	73	Хангалттай	57	69	91
2	Үндэсний аудитын газар	71	Хангалттай	54	68	90
3	Тагнуулын ерөнхий газар	64	Сул	43	60	87
4	Хүний эрхийн үндэсний комисс	63	Сул	43	62	84
5	Сонгуулийн ерөнхий хороо	63	Сул	41	60	87
6	Авлигатай тэмцэх газар	60	Сул	38	56	84
7	Монгол улсын их хурал	54	Сул	30	50	80
8	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	45	Хангалтгүй	19	41	72
9	Үндэсний геологийн алба	31	Муу	8	27	57
10	Жендерийн үндэсний хороо	19	Муу	2	14	39

3. Дүгнэлт, зөвлөмж

Дүгнэлт

2025 оны цахим ил тод байдлын индексийн үнэлгээгээр Монгол Улсын 98 төрийн байгууллагын нэгдсэн дундаж оноо 45 / 100 болж, “хангалтгүй” түвшинд үнэлэгдлээ. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт харьцангуй тогтворжиж “хангалттай” түвшинд үнэлэгдсэн боловч бусад шалгуураар “хангалтгүй” үнэлэгдэж байгаа нь энэхүү үр дүнд нөлөөлсөн. Хуулийн хэрэгжилтийн бүрэлдэхүүн харьцангуй өндөр байгаа нь сүүлийн жилүүдэд шилэн данс, мэдээллийг цахимд байршуулах практик тогтсоны үр дүн юм. Харин мэдээлэл авах эрхийн хэрэгжилт 24 оноотой, нээлттэй өгөгдөл 41 оноотой байгаа нь тайлангийн онцлох дүгнэлтүүдийн суурь болж байна.

Мэдээлэл авах эрхийг бодитоор хангах байдал “муу” 24/100

2025 оны шинэчилсэн арга зүйн хамгийн чухал хэсэг нь мэдээлэл хүсэх бодит хүсэлт илгээж, түүний хариу үйлдлийг хэмжсэн практик тест байв. 98 байгууллагын бүртгэлтэй и-мэйл хаягт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан эрхийн дагуу хоёр төрлийн хүсэлт илгээсэн. Үр дүнгээс харахад нийт байгууллагын 88 хувь нь мэдээлэл хүсэх форм эсвэл и-мэйл хаягтай байсан ч 69 хувь нь хуульд заасан ажлын тав хоногийн хугацаанд огт хариу ирүүлээгүй байна. Хариу өгсөн байгууллагуудын дотор ч зөвхөн 3 хувь нь хүссэн мэдээллийг бүрэн, шаардлагад нийцсэн хэлбэрээр хүргүүлжээ. Бусад тохиолдолд вэбсайтын холбоос эсвэл утасны дугаар дамжуулах, цаасан хүсэлт шаардах, хүсэлтийн зорилгыг тайлбарлуулах зэрэг нэмэлт

шаардлага тавьсан байна. Эдгээрийн зарим нь хуулийн шаардлагыг шууд зөрчсөн үйлдэлд тооцогдохоор байв.

Үүнээс 2025 оны үнэлгээний онцлох дүгнэлт болох цаасан дээрх ил тод байдал болон бодит ил тод байдлын хооронд мэдэгдэхүйц зөрүү байгааг харуулж байна.

Энэ нь тохиолдлын шинжтэй бус, харин тогтолцооны түвшний дутагдал байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, мэдээлэл авах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу хүргүүлэхтэй холбоотой дотоод хариуцлагын тогтолцоо, хяналтын механизм, хугацааны хэрэгжилтийг хангах зохицуулалт байгууллагуудын дийлэнхэд бүрдээгүй байна.

Нээлттэй өгөгдлийг ашиглагдахуйц байдал “хангалтгүй” 41/100

Нээлттэй өгөгдлийн бүрэлдэхүүн 41/100 оноотой байгаа нь мэдээлэл нийтлэгдэж байгаа хэдий ч шинжилгээ хийх, дахин ашиглах боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна. Байгууллагуудын дийлэнх нь мэдээллийг PDF хэлбэрээр нийтэлдэг бөгөөд энэ нь иргэн уншихад тохиромжтой боловч компьютероор боловсруулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх, дахин ашиглахад хүндрэлтэй формат юм. Харин CSV, Excel, API зэрэг машинд уншигдах нээлттэй форматыг ашиглаж буй байгууллагын эзлэх хувь нийт байгууллагын 20 хувьд ч хүрэхгүй байна.

Энэ нь зөвхөн техникийн шинжтэй асуудал биш юм. Монгол Улс 2025 онд Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлэн болгосон. Гэвч хиймэл оюун ухаан ашиглах, өгөгдлийг

нэгтгэн шинжлэх, төрийн үйлчилгээ болон бодлого боловсруулалтад өгөгдөлд суурилсан шийдэл нэвтрүүлэх боломж нь байгууллага бүрийн нийтэлж буй өгөгдлийн чанар, бүтэц, стандарттай шууд холбоотой. Бүтэцгүй, хоцрогдсон, стандартчилалгүй өгөгдлийн орчинд аливаа технологийн дэвшил, хиймэл оюунд суурилсан шийдлийг үр дүнтэй хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал хэвээр байх болно.

Нээлттэй мэдээлэл - хуулийн хэрэгжилт 'хангалттай' тогтворжсон 68/100

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн хувьд хуулийн хүрээнд 68 заавал нийтлэх мэдээллийн биелэлт 68 / 100 оноотой гурван бүрэлдэхүүний хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Байгууллагуудын дийлэнх нь бүтэц, удирдлага, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийг тогтмол нийтэлдэг болсон нь сүүлийн жилүүдийн бодит ахиц юм.

Гэвч мэдээлэл байршсан байх нь хяналт тавих боломж бүрдсэн гэсэн үг биш. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байгууллагуудын талаас илүү хувьд нийтлэгдэх тохиолдол ховор, шилэн дансны мэдээлэл хугацаа хоцорч нийтлэгдэх зэрэг асуудал нийтлэг хэвээр

байна. Ил тод байдал нь зөвхөн мэдээлэл нийтлэх үйл ажиллагаа бус харин хяналт тавих боломж бүрдэх үйл явц тул цаг хугацааны хувьд ач холбогдлоо алдаагүй, иргэдэд ойлгомжтой, тодорхой хэлбэрээр мэдээллийг байршуулахад анхаарах шаардлагатай юм.

Байгууллагуудын хоорондын ялгаа нэмэгдэж байна – 60 онооны зөрүү

Тэргүүлэгч байгууллагуудын ил тод байдлын индекс 75–79 байхад хамгийн бага индекстэй байгууллагууд 17–19 байгаа нь 60 гаруй онооны зөрүүтэй байна. Тэргүүлэгч байгууллагуудад өгөгдлийн менежмент, чадавхтай хүний нөөц, технологийн шийдэл харьцангуй сайн бүрдсэн бол сул байгууллагуудад эдгээр хүчин зүйлсийн аль аль нь дутмаг байна.

Газарзүйн хэмжээнд харахад уул уурхайн орлоготой аймгууд (Орхон, Дархан-Уул) өндөр оноотой, баруун болон алслагдсан аймгуудын ихэнх нь 30-аас доош оноотой байгаа нь нөөц, дэд бүтцийн тэгш бус байдлыг харуулж байна. Нийслэлийн Налайх, Багануур, Багахангай дүүргүүд тогтмол хамгийн бага үзүүлэлттэй гардаг нь дэд бүтэц, хүний нөөцийн хуваарилалтын тусгай анхаарал шаарддаг гэдгийг нотолж байна.

Зөвлөмж

Засгийн Газарт зориулсан зөвлөмж

Нэгдүгээрт, мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийг хянах тогтолцоог бодлогын шаардлага болгох. Байгууллага бүрд мэдээлэл авах хүсэлтийг хариуцах ажилтан, дотоод журам тогтоох эрх зүйн шаардлагыг нэвтрүүлэх. Хуульд заасан хугацааны үйл явцыг цахимаар хянах, үр дүнг нэгтгэн статистикийг улсын хэмжээнд жил бүр нийтлэх технологийн тогтолцоог хөгжүүлэх. Хариу өгдөггүй байгууллагуудыг нийтэд ил болгох нь хамгийн хялбар боловч хамгийн бодит хөшүүрэг болно.

Хоёрдугаарт, Хэдийгээр нээлттэй өгөгдөл бий болгох, нийтлэхтэй холбоотой зохицуулалт болон Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн системийн үйл ажиллагааны журам мөрдөгдөж байгаа боловч байгууллагуудын хэрэгжилтийн түвшин харилцан адилгүй байна. Иймд нээлттэй өгөгдлийн формат, бүтэц, чанар болон шинэчлэлтийн шаардлагыг илүү нэгдсэн байдлаар мөрдүүлэх хэрэгцээ байна.

Гуравдугаарт, Санал болгон ашиглаж буй 5 түвшний ангиллыг бодлогын хэрэгсэл болгох. "Муу" болон "Хангалтгүй" ангиллын 58 байгууллагуудад чадавх бэхжүүлэх сургалт, техникийн туслалцаа үзүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх.

Төрийн захиргааны байгууллагуудад

Нэгдүгээрт, мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөх дотоод тогтолцоо бий болгох. Хүсэлт хүлээн авах, хариуцсан ажилтанд дамжуулах, хугацааг хянах, хариу илгээх дараалсан журам тогтоох нь нэн тэргүүний алхам юм. Мөн тухайн хүсэлтийн статистик, үр дүнг нэгтгэн тайлагнах үйл явцыг сайжруулах нь мэдээлэл авах эрхийн хэрэгжилтийг хангахад чухал ач холбогдолтой.

Хоёрдугаарт, PDF-тэй зэрэгцүүлэн Excel, CSV форматаар мэдээлэл нийтлэх. Тендерийн дүн, санхүүгийн тайлан, хүний нөөцийн

мэдээллийг нийтлэхдээ PDF-тэй зэрэгцүүлэн Excel эсвэл CSV форматаар нэмж байршуулах нь нэмэлт хөдөлмөр бага шаарддаг ч иргэд, судлаачдын хувьд мэдээллийг шинжлэх, харьцуулах боломжийг эрс нэмэгдүүлдэг.

Гуравдугаарт, иргэдийн санал, хүсэлтийг хүлээн авах онлайн форм нэвтрүүлэх. Зөвхөн утас, и-мэйлийн хажуугаар энгийн онлайн мэдүүлгийн форм байршуулах нь нэн даруй хэрэгжүүлж болох алхам юм.

Иргэний нийгэм, судлаачдад

Нэгдүгээрт, мэдээлэл авах эрхийн практик тестийг жил бүр бие даасан байдлаар хэрэгжүүлэх. Байгууллага хуульд заасан хугацаанд хариу өгч байгаа эсэх, өгсөн хариу нь хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг иргэний нийгмийн байгууллагууд тогтмол шалгаж, олон нийтэд мэдээлдэг болох нь IRIM-ийн үнэлгээг нэмэлт бие даасан эх сурвалжаар баяжуулна.

Хоёрдугаарт, мэдээлэл авах эрхийн хүсэлт гаргах зааврыг иргэдэд хүртээмжтэй болгох. Манай судалгааны практик тестийн үр дүнгээс харахад байгууллагуудын зарим нь хуульд заасны эсрэгээр хүсэлт гаргагчаас зорилго, үндэслэл тодруулахыг шаардах, цаасан хүсэлт шаардах зэрэг нэмэлт саад тавьж байна. Иргэд мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэхдээ хүсэлтийн зорилгоо тайлбарлах шаардлагагүй гэдгийг мэддэг байх нь ийм төрлийн зөрчилд хариу үйлдэл үзүүлэх, эрхээ хамгаалах боломжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

Гуравдугаарт, тодорхой хугацааны давтамжтайгаар иргэдийн дунд судалгаа явуулах. Вэбсайтын техникийн үзүүлэлт сайн байлаа ч иргэд бодитоор мэдээлэлд хандаж чадаж байгаа эсэх нь тусдаа үнэлгээ юм. Иргэдийн туршлагыг шууд асуух судалгаа нь цахим ил тод байдлын индекстэй хосолж, төрийн байгууллагын цахим ил тод байдлын дүр зургийг илүү бүрэн харуулна.

Ашигласан эх сурвалжууд

- Boyuan Zhao, S. C. (2023). Digital transparency and citizen participation: Evidence from the online crowdsourcing platform of the City of Sacramento. *Government Information Quarterly*. doi:<https://doi.org/10.1016/j.giq.2023.101868>.
- Cabinet Office UK. (2023). *Freedom of Information statistics: July to September 2023 bulletin*. <https://www.gov.uk/government/statistics/freedom-of-information-statistics-july-to-september-2023/freedom-of-information-statistics-july-to-september-2023-bulletin>-ээс Гаргасан
- Cabinet Office UK. (2025 оны April 30). *Freedom of Information statistics: annual 2024 bulletin*. Гаргасан 2026, <https://www.gov.uk/government/statistics/freedom-of-information-statistics-annual-2024/freedom-of-information-statistics-annual-2024-bulletin-aac>
- Chandrasekhar, R. &. (2025). Sustainable open data ecosystems through data quality, governance, and infrastructure.
- CPI. (2024). *CPI*. <https://files.transparencycdn.org/images/CPI-2023-Report.pdf>-ээс Гаргасан
- DESA, U. (2024). *UN E-Government Survey 2024: Accelerating Digital Transformation for Sustainable Development*.
- Government Transformation Magazine. (огноо байхгүй).
- McIntosh, T. (2024). *More Than 55 Countries Lack ATI Laws: Why Not? And What's Being Done*. *Eye on Global Transparency*.
- OECD. (2013). *Open Government Data: Towards Empirical Analysis of Open Government Data Initiatives*.
- OECD. (2017). *G20/OECD Compendium of Good Practices on the Use of Open Data for Anti-Corruption*. OECD Publishing.
- OECD. (2017). *Recommendation of the Council on Open Government*. paris.
- OECD. (2017). *Recommendation of the Council on Open Government*.
- OECD. (2023). *OECD Open, Useful and Re-usable data (OURdata) Index*.
- Open Government Partnership [OGP]. (2023). *Open Government Foundations: Mainstreaming Participation*.
- Prabhu, J. (2021). *How should a government be?*
- Rivero, G. (2020). *Do FOI laws and open government data deliver as anti-corruption policies?* *Government Information Quarterly*.
- Sangathan, S. N. (2022). *Report card of information commissions in India 2021–22*. <https://www.snsindia.org/wp-content/uploads/2022/12/Report-Card-2022.pdf>-ээс Гаргасан
- The Asia Foundation. (2014). *Citizens' access to information in South Asia*. https://www.academia.edu/10410969/Citizens_access_to_information_in_South_Asia-ээс Гаргасан
- UN. (2025). *Access to Information: A Cornerstone of Sustainable Development, Human Rights and Environmental Resilience*. *UN Chronicle*. <https://www.un.org/en/chronicle>-ээс Гаргасан
- UNDP. (2023). *Evaluation of UNDP Support to Digitalization of Public Services*.
- UNESCO. (2025). *The Right to Access to Information*.
- World Bank. (2022). *World Development Report*.
- World Bank. (2023). *Worldwide Governance Indicators*.

Хавсралт 1. Байгууллагын 5 түвшний эрэмбэ

Нийт 98 байгууллагыг нэгдсэн индексийн оноогоор нь 5 түвшинд ангилсан эрэмбэ

Сайн | >80

Хангалттай | 65-79

Сул | 50-64

Хангалтгүй | 35-49

Муу | <35

Түвшин	Эрэмбэ	Байгууллагын нэр	Цахим ил тод байдлын индекс
≥ 80 Сайн	Энэ түвшинд үнэлэгдсэн байгууллага байхгүй.		
65-79 Хангалттай Мэдээлэл байршдаг ч стандарт жигд биш	1	Үндэсний статистикийн хороо	79
	2	Татварын ерөнхий газар	79
	3	Улсын бүртгэлийн ерөнхий газар	77
	4	Сангийн яам	75
	5	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар	75
	6	Цахим хөгжил, иноваци, харилцаа холбооны яам	75
	7	Гаалийн ерөнхий газар	74
	8	Харилцаа холбоо зохицуулах хороо	73
	9	Монгол банк	73
	10	Үндэсний аудитын газар	71
	11	Төрийн худалдан авах ажиллагааны газар	71
	12	Орхон аймаг	71
	13	Эдийн засаг, хөгжлийн яам	70
	14	Дархан-Уул аймаг	67
	15	Боловсрол, шинжлэх ухааны яам	65
50-64 Сул Ил тод байдал дутуу, бэхжүүлэх шаардлагатай	16	Тагнуулын ерөнхий газар	64
	17	Хүний эрхийн үндэсний комисс	63
	18	Ашигт малтмал, газрын тосны газар	63
	19	Сонгуулийн ерөнхий хороо	63
	20	Өмнөговь аймаг	63
	21	Эрүүл мэндийн яам	62
	22	Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам	60
	23	Сэлэнгэ аймаг	60
	24	Стандарт, хэмжил зүйн газар	60
	25	Авлигатай тэмцэх газар	60
	26	Хил хамгаалах	60
	27	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар	58
	28	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам	58
	29	Боловсролын ерөнхий газар	57
	30	Хөвсгөл аймаг	56
	31	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам	55
	32	Цагдаагийн ерөнхий газар	54
	33	Нийгмийн даатгалын ерөнхий газар	54
	34	Монгол улсын их хурал	54
	35	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	52
	36	Ховд аймаг	52
	37	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуулын яам	52
	38	Нийслэлийн ЗДТГ	52
	39	Хан-Уул дүүрэг	52

Түвшин	Эрэмбэ	Байгууллагын нэр	Цахим ил тод байдлын индекс	
	40	Дорнод аймаг	51	
	41	Баянзүрх дүүрэг	51	
	42	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ЕГ	50	
35–49 Хангалтгүй Мэдээлэл хязгаарлагдмал	43	Архангай аймаг	49	
	44	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	49	
	45	Сонгинохайрхан дүүрэг	48	
	46	Эрчим хүчний яам	47	
	47	Онцгой байдлын ерөнхий газар	47	
	48	Улаанбаатар хотын захирагчийн алба	45	
	49	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	45	
	50	Иргэний нисэхийн ерөнхий газар	44	
	51	Булган аймаг	45	
	52	Хууль зүй, дотоод хэргийн яам	43	
	53	Хэнтий аймаг	42	
	54	Баянгол дүүрэг	42	
	55	Хөрөнгө оруулалт худалдааны газар	42	
	56	Шүүх шинжилгээний ерөнхий газар	40	
	57	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ЕГ	40	
	58	Сүхбаатар дүүрэг	39	
	50	Гадаад харилцааны яам	39	
	60	Зэвсэгт хүчний жанжин штаб	39	
	61	Сүхбаатар аймаг	38	
	62	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар	37	
	63	Мал эмнэлгийн ерөнхий газар	37	
	64	Санхүүгийн зохицуулах хороо	36	
	65	Эрчим хүчний зохицуулах хороо	36	
	66	Дорноговь аймаг	36	
	67	Батлан хамгаалах яам	35	
	68	Баян-Өлгий аймаг	35	
	69	Чингэлтэй дүүрэг	35	
	< 35 Муу Мэдээлэл хязгаарлагдмал	70	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар	34
		71	Төрийн албаны зөвлөл	32
		72	Төв аймаг	31
		73	Үндэсний геологийн алба	31
		74	Монополын эсрэг газар	29
		75	Завхан аймаг	29
76		Зам, тээврийн хөгжлийн яам	27	
77		Архивын ерөнхий газар	27	
78		Говь-Алтай аймаг	27	
79		Гадаадын иргэн, харьяатын газар	26	
80		Оюуны өмчийн газар	26	
81		Увс аймаг	26	
82		Налайх дүүрэг	26	
83		Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	24	
84		Аж үйлдвэр, эрдэс баялагийн яам	24	
85		Баянхонгор аймаг	24	
86		Цаг уур, орчны шинжилгээний газар	23	

Түвшин	Эрэмбэ	Байгууллагын нэр	Цахим ил тод байдлын индекс
	87	Дундговь аймаг	23
	88	Биеийн тамир, спортын улсын хороо	22
	89	Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын ЕГ	21
	90	Багануур дүүрэг	21
	91	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар	21
	92	Ойн газар	20
	93	Говьсүмбэр аймаг	20
	94	Усны газар	19
	95	Жендерийн үндэсний хороо	19
	96	Соёл, урлагийн газар	18
	97	Багахангай дүүрэг	18
	98	Жижиг, дунд үйлдвэрийн газар	17